




ᠰᠠᠨᠬᠡᠭᠦᠭᠢᠢᠨ  
ᠵᠣᠬᠢᠴᠢᠭᠤᠯᠠᠬᠤ  
ᠬᠣᠷᠤᠨ  
ᠲᠤᠶᠢᠮ



# САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТӨЙМ

2022 ОН

# АГУУЛГА

## I. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн зах зээлийн төлөв

8

Хүртээмжтэй байдал

11

Бүтээгдэхүүн үйлчилгээ

13

Ашигт ажиллагаа

16

Тогтвортой байдал

20

Бодлого зохицуулалт

21

## II. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн зах зээлийн төлөв

24

Хүртээмжтэй байдал

28

Бүтээгдэхүүн үйлчилгээ

31

Ашигт ажиллагаа

33

Тогтвортой байдал

34

Бодлого зохицуулалт

35

## III. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Санхүүгийн зах зээлийн төлөв

38

Хүртээмжтэй байдал

43

Бүтээгдэхүүн үйлчилгээ

46

Ашигт ажиллагаа

50

Тогтвортой байдал

52

Бодлого зохицуулалт

54

## IV. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Санхүүгийн зах зээлийн төлөв

58

Хүртээмжтэй байдал

60

Бүтээгдэхүүн үйлчилгээ

64

Ашигт ажиллагаа

68

Тогтвортой байдал

70

Бодлого зохицуулалт

72

## V. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Санхүүгийн зах зээлийн төлөв	Хүртээмжтэй байдал	Бүтээгдэхүүн үйлчилгээ	Ашигт ажиллагаа	Тогтвортой байдал
------------------------------	--------------------	------------------------	-----------------	-------------------

76

77

79

80

81

## VI. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ

Салбарын төлөв	Хүртээмжтэй байдал	Бүтээгдэхүүн үйлчилгээ	Ашигт ажиллагаа	Тогтвортой байдал	Бодлого зохицуулалт
----------------	--------------------	------------------------	-----------------	-------------------	---------------------

84

87

88

91

92

93

## VII. ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧ

Салбарын төлөв	Хүртээмжтэй байдал	Бүтээгдэхүүн үйлчилгээ	Ашигт ажиллагаа	Бодлого зохицуулалт
----------------	--------------------	------------------------	-----------------	---------------------

96

97

98

99

100

## VIII. СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Зохицуулалтын орчны төлөв	Сэндбоксад туршигдаж буй бүтээгдэхүүнүүд
---------------------------	--

103

103

## IX. ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ







Салбарын төлөв	Бодлого зохицуулалт
----------------	---------------------

106

108

# ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНУ	Америкийн Нэгдсэн Улс	ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
АХБ	Азийн хөгжлийн банк	ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага	ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	ХОС	Хөрөнгө оруулалтын сан
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн	МАPIX	Монголын хөдөө аж ахуйн барааны үнийн индекс
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас	ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү	AFI	Alliance for Financial Inclusion / Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг/
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ	ATM	Automated teller machine /Автомат теллер машин/
МИК	Монголын ипотекийн корпораци	ESG	Environmental, Social, Governance /Байгаль орчин, нийгэм, засаглал/
МХЗХҮХ	Монголын хадгаламж, зээлийн хоршооны үндэсний холбоо	JICA	Japan International Cooperation Agency /Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага/
МХБ	“Монголын хөрөнгийн бирж” ХК	IAIS	International Association of Insurance Supervisors /Олон улсын даатгалын зохицуулагчдын холбоо/
МҮЦБ	“Монголын үнэт цаасны бирж” ХК	IPO	Initial public offering /Олон нийтэд хувьцаагаа санал болгох/
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага	FPO	Follow up on public offering /Нэмэлт хувьцаа гаргах/
ТДЦА	Татварын дараах цэвэр ашиг	MSE	Mongolian stock exchange /Монголын хөрөнгийн бирж/
ТЗК	Тусгай зориулалтын компани	UNEP FI	Нэгдсэн үндэсний байгууллагын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүжилтийн санаачилга
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци		
УҮГ	Улсын үйлдвэрийн газар		
ҮХЭХБХСЗ	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлал		
ҮХЭХЗ	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал		
ҮЦК	Үнэт цаасны компани		
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв		
ХААБ	Хөдөө аж ахуйн бирж		
ХЖДХ	Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү		
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо		
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө		
ХК	Хувьцаат компани		

 <p>ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ</p>	<p>Зах зээлийн үнэлгээ <b>6,890.4</b> тэрбум төгрөг</p> <p>ЗЗУ/ДНБ <b>14.3%</b></p>	<p>Нийт хөрөнгө <b>474.9</b> тэрбум төгрөг</p>	<p>ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ</p> 
<p>ТОП-20 индекс <b>37,565.55</b></p>	<p>Арилжааны дүн <b>594.9</b> тэрбум төгрөг</p>	<p>Даатгалын болон давхар даатгалын нийт хураамж <b>304.8</b> тэрбум төгрөг</p>	<p>Даатгалын нөхөн төлбөр <b>94.2</b> тэрбум төгрөг</p>
<p>ҮЦК-ийн тоо <b>52</b></p>	<p>Хөрвөх чадвар <b>2.4%</b></p>	<p>Цэвэр ашиг <b>18.5</b> тэрбум төгрөг</p>	<p>Нөөц сан <b>216.9</b> тэрбум төгрөг</p>
<p>MSE A <b>14,137.94</b></p> <p>MSE B <b>12,667.44</b></p>	<p>ХАА-н гаралтай барааны арилжааны хэмжээ <b>1,110.0</b> тэрбум төгрөг</p>	<p>Гүнзгийрэлт <b>0.63%</b></p>	<p>Нягтрал <b>87,816</b> төгрөг</p>
		<p>Даатгалын компанийн тоо <b>18</b></p>	<p>Давхар даатгалын хураамжийн зардал <b>100.0</b> тэрбум төгрөг</p>
 <p>БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА</p>	<p>Тусгай зөвшөөрөлтэй <b>513</b> ББСБ</p>	<p><b>93.0 %</b> Зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй</p>	<p>Тусгай зөвшөөрөлтэй <b>196 ХЗХ</b></p>
<p>Нийт хөрөнгө <b>3.5</b> их наяд төгрөг</p>	<p><b>4.6 сая</b> Харилцагч</p>	<p>Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь <b>3.4%</b></p>	<p>ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО</p> 
<p>Нийт зээл <b>2.7</b> их наяд төгрөг</p>	<p>Нийт зээлдэгч <b>1.2</b> сая</p>	<p>Нийт хөрөнгө <b>267.7</b> тэрбум төгрөг</p>	<p>Нийт хадгаламж <b>187.5</b> тэрбум төгрөг</p>
<p>Зээлийн жигнэсэн дундаж хүү <b>3.1%</b></p>	<p>Нийт орлого <b>867.8</b> тэрбум төгрөг</p> <p>Хүүгийн орлого <b>701.9</b> тэрбум төгрөг</p>	<p><b>2.3%</b> Зээлийн жигнэсэн дундаж хүү</p>	<p>НИЙТ ЗЭЭЛ <b>210.2</b> тэрбум төгрөг</p>
<p>Зээлийн жигнэсэн дундаж хүү <b>3.1%</b></p>			<p><b>1.2%</b> Хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү</p>
 <p>ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ</p>	<p>ҮХЭХЗ-ын байгууллага <b>305</b></p>	<p>Иргэн <b>465</b></p> <p>Хуулийн этгээд <b>47</b></p>	<p>ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУ</p> 
<p><b>1,705.3</b> тэрбум төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийг зуучлан худалдав</p>	<p><b>444.1</b> тэрбум төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийг зуучлан түрээслүүлэв</p>	<p>Үнэт металл худалдан авалт <b>700.1</b> тэрбум төгрөг</p>	<p>Үнэт металлын борлуулалт <b>670.8</b> тэрбум төгрөг</p>



# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлийн үнэлгээ

**6,890.4**  
тэрбум төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Дансны тоо  
**2,446,290**



Хүртээмжтэй байдал

Нийт арилжааны дүн  
**594.9** тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



ҮЦК-ийн хөрөнгө

**189.3**

тэрбум төгрөг

Улсад татан  
төвлөрүүлсэн  
татвар, НДШ  
(ҮЦК, ХОМК)

**4.7**

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Төвлөрөл 3ЗҮ-ний

**74.2 хувийг**

Топ-10 ХК

Бодлого зохицуулалт



## САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ



Үнэт цаасны зах зээлд нийт **595** зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байна

Арилжаа эрхлэх <b>3</b>	Төвлөрсөн хадгаламж, үнэт цаасны арилжааны төлбөрийн <b>1</b>	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэл хянагч <b>1</b>
ХОМК <b>38</b>	Тооцооны <b>2</b> /1 давхардсан/	Кастодиан <b>3</b>
Андеррайтерийн зөвшөөрөлтэй банк <b>2</b>	Хөрөнгө итгэмжлэн удирдах <b>8</b>	ХК <b>318</b>
ҮЦК* <b>52</b>	ХАА түүхий эдийн арилжаа эрхлэх <b>1</b>	ХАА түүхий эдийн брокер <b>10</b>
ҮЦЗЗ-д аудитын үйлчилгээ үзүүлэх <b>48</b>	ҮЦЗЗ-д хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх <b>24</b> /6 давхардсан/	ҮЦЗЗ-д хуулийн үйлчилгээ үзүүлэх <b>37</b>
Хамтын хөрөнгө оруулалтын сан <b>4</b>	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч <b>49 /ТЗК/</b>	Өөрийгөө зохицуулах байгууллага <b>2</b> /1 давхардсан/


Хувийн хөрөнгө оруулалтын сан (Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 5.3 дахь заалт)  
**29**

\*ҮЦК-д брокер, дилер, андеррайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагыг хамаатуулна.

### Үнэт цаасны зах зээлийн арилжаа


- 2022 онд нийт 594.9 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжаалагдсан бөгөөд энэ нь 2021 оноос 2.4 дахин буурсан бол 2018 оноос 2.4 дахин өссөн байна.
- Нийт арилжааны 22.5 хувийг компанийн бондын, 2.3 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн, 17.5 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 57.7 хувийг хувьцааны арилжаа тус тус эзэлж байна.

Үнэт цаасны арилжаа /тэрбум төгрөг/




### Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар

- Зах зээлийн үнэлгээ өмнөх онтой харьцуулахад 15.2 хувиар өсөж 6.9 их наяд төгрөгт хүрсэн бол хувьцааны арилжааны хоёрдогч зах зээлийн дүнгээр тооцсон хөрвөх чадвар 1.4 пунктээр буурч 2.4 хувьд хүрлээ.
- Хөрвөх чадвар буурахад хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа 62.7 тэрбум төгрөгөөр буюу 0.3 дахин буурсан нь голлон нөлөөлжээ.



### 33Y/ДНБ /хувиар/



Эх сурвалж: [www.worldbank.org](http://www.worldbank.org)

- Монголын Үнэт цаасны зах зээлийн үнэлгээг ДНБ-д харьцуулсан дүнг FTSE жагсаалтад багтах frontier зах зээлийн улс орнуудтай харьцуулахад 3 дугаарт жагсаж байна.

## ШИГТГЭЭ

Төв банкнуудаас мөнгөний бодлогоо чангаруулсан нь дэлхийн эдийн засгийн эрэлтийг бууруулж, ОХУ–Украины дайны нөхцөл байдлаас үүдэн эрчим хүч, хүнсний үнэ өсөж, БНХАУ–ын Ковид 19 цар тахлын хөл хорионоос үүдэлтэй эдийн засгийн хүндрэл үргэлжилсээр байх тул JP Morgan–ны шинжээчид “Дэлхийн эдийн засаг 2023 онд 1.6 орчим хувиар өсөх төлөвтэй” гэж таамаглаж байна.

Түүнчлэн 2022 онд S&P 500–ийн үнэ ашгийн харьцаа (P/E) долоо дахин буурсан ба 2023 онд нэгж хувьцаанд ногдох ашгийг (EPS) зөвшилцсөнөөс доош буюу 225 доллараас 205 доллар болгон бууруулжээ.

Эх сурвалж: *Economic and market forecasts for 2023 from J.P. Morgan Global Research*



**ТОП 20 37,565.55**

**MSE A 14,137.94**

**MSE B 12,667.44**

**Үнэт цаасны зах зээлийн индекс**

- ТОП–20 Индекс өмнөх онтой харьцуулахад 6,846.1 нэгжээр буюу 15.4 хувиар буурсан.
- MSE A индекс өмнөх оноос 1,344.8 нэгжээр буюу 8.7 хувиар буурсан.
- MSE B индекс өмнөх оноос 464.9 нэгжээр буюу 3.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



ХААБ–ээр нийт 1,110.0 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оноос 315.4 тэрбум төгрөгөөр буюу 39.8 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд 8 төрлийн бүтээгдэхүүн арилжигджээ.



ХААБ–ээр нийт 8 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдсаны дотор бодын хөөвөр 13.7 сая төгрөг, мал бэлтгэл 2.0 сая төгрөг байна.


## ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ТОП-20 ИНДЕКСЭД БАГТАХ ХК-УУДЫН САЛБАРЫН АНГИЛАЛ /ЗЗҮ-ЭЭР/




## ХУВЬЦААНЫ ТӨВЛӨРӨЛ

- Хөрөнгийн бирж дээр идэвхтэй арилжаа явуулдаг 166 ХК-ийн төвлөрлийг хувьцааны 5-аас дээш хувийг болон түүнээс доош хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигчдийн хувиар тооцож доорх хүснэгтэд харуулав.



- 2022 онд 17,569 данс нээгдэж нийт дансны тоо 2,446,290-т хүрсэн бол 68,654 холболтын данс нээгдэж холболтын дансны тоо 532,729-т хүрлээ.
- 2021 онтой харьцуулахад нийт дансны тоо 0.7 хувиар нэмэгдсэн.



НИЙТ ДАНСНЫ ТОО  
/ӨССӨН ДҮНГЭЭР/



**2,446,290**

## ҮЦТХТ-Д БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС



## ҮЦК БОЛОН ХАА-Н БРОКЕРЫН КОМПАНИУДЫН БАЙРШИЛ

- 2022 онд Улаанбаатар хотод нийт 52 ҮЦК болон тэдгээрийн 36 салбар үйл ажиллагаа явуулав. Нийт салбарын 34 нь орон нутагт, 2 нь Улаанбаатар байршилтай.
- 2022 онд нийт 10 ХАА-н брокер үйл ажиллагаа явуулж байгаагийн 7 нь Улаанбаатар хотод, 3 нь орон нутагт байршиж байна.




## САЛБАР ТӨЛӨӨЛӨГЧИД



## БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ


■ Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/



### ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

- 2022 онд хувьцааны арилжаа 343.4 тэрбум төгрөгт хүрсэн нь 2018 онтой харьцуулахад 63.3 хувиар, өмнөх онтой харьцуулахад 12.6 хувиар тус тус өсжээ.

■ Компанийн өрийн хэрэгслийн арилжаа /тэрбум төгрөг/



### КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АРИЛЖАА

- 2022 онд компанийн бондын арилжаа 134.1 тэрбум төгрөгт хүрсэн нь 2018 онтой харьцуулахад 79 дахин өсөж, 2021 оноос 7.8 дахин тус тус буурчээ.

## ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН

### ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

- “МИК ОССК” ХХК–аас үүсгэн байгуулсан 32 ТЗК–ийн хүрээнд нийт 104,660 зээлдэгчийн ипотекийн зээлийг үнэт цаасжуулж 6.2 их наяд төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлж 2022 онд нийт 67,103 зээлдэгчийн 3.4 их наяд төгрөгийн баталгаат үнэт цаасны үлдэгдэлтэй байна. Тайлант хугацаанд 17,684 зээлдэгчийн ипотекийн зээлийг багцлан 1,324.4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгүүлсэн байна.

№	Бодлогын баримт бичиг	Үнэт цаас гаргагч	Бүртгэсэн огноо	Хөрөнгийн тоо	ХБҮЦ дүн
1		"МИК актив хорин ес" ХХК	2022.07.06	7,309	532.8
2	"Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох" хөтөлбөрийн хүрээнд	"МИК актив гуч" ХХК	2022.11.09	1,536	94.3
3		"МИК актив гучин нэг" ХХК	2022.12.02	911	64.1
4		"МИК актив гучин хоёр" ХХК	2022.12.09	7,928	633.2
НИЙТ				17,684	1,324.4

- Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”–ийн хэрэгжүүлэх дэд арга хэмжээний хүрээнд “Үнэт цаасны санхүүжилтийн корпораци”–аас 4 ТЗК үүсгэн байгуулж, хаалттай хүрээнд уул уурхайн бус экспортын салбарын болон жижиг, дунд үйлдвэрлэгчид олгосон нийт 2,298 зээлийг багцлан 538.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргасан. Тайлант хугацаанд 1,037 зээлийг багцлан 329.4 тэрбум төгрөгийн уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрийн зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаас бүртгүүлсэн байна.

№	Бодлогын баримт бичиг	Үнэт цаас гаргагч	Бүртгэсэн огноо	Хөрөнгийн тоо	ХБҮЦ дүн
1	УИХ–ын 2020 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан	"ҮЦСК актив гурав ТЗК" ХХК	2022.06.22	712	217.6
2	"Зээлийн хүүг бууруулах стратеги"–ийн хүрээнд	"ҮЦСК актив дөрөв" ХХК	2022.09.21	325	111.8
НИЙТ				1,037	329.4

## ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН

### ШИНЭЭР БОЛОН НЭМЖ ГАРГАСАН ХУВЬЦАА

- 2005 оноос 2022 онд нийт 30 компани IPO хийж нийт 348.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг анхдагч зах зээлээс татан төвлөрүүлсэн байна. Монголын анхны нэмж хувьцаа гаргах замаар хөрөнгө татан төвлөрүүлэх арилжаа 2007 онд явагдсанаас хойш 2022 онд давхардсан тоогоор 14 компани 15 удаагийн арилжаагаар нийт 80.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг нэмэлт хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлжээ.

Гаргасан компани	Бүртгэсэн огноо	Татан төвлөрүүлсэн дүн
<b>ХААЛТТАЙ</b>		
"Шарын гол" ХК-ийн өрийг хувьцаагаар солих зорилгоор хаалттай хүрээнд гаргасан энгийн хувьцаа	2022.01.26	0.2
"Блюскэй секьюритиз УЦК" ХК-ийн хаалттай хүрээнд нэмж гаргасан энгийн хувьцаа	2022.03.09	0.6
"Тандэм инвест ББСБ" ХК-ийн хаалттай хүрээнд нэмж гаргасан энгийн хувьцаа	2022.06.08	0.9
<b>Олон нийтэд шинээр болон нэмж гаргасан хувьцаа /IPO&amp;FPO/</b>		
"Эрдэнэс сольюшинс" ХК-ийн нийтэд санал болгон нэмж гаргаж буй хувьцаа	2022.05.25	1.9
"Инвекор ББСБ" ХК-ийн нийтэд санал болгон нэмж гаргаж буй хувьцаа	2022.06.08	16.7
"Мон бийф" ХК-ийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцаа	2022.06.22	2.9
"Сэндли ББСБ" ХХК-ийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцаа	2022.08.10	10.1
"Төрийн банк" ХХК-ийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцаа	2022.09.21	25.4
"Голомт банк" ХХК-ийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцаа	2022.11.09	118.8
"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нийтэд санал болгон нэмж гаргаж буй хувьцаа / төрийн өмчийн хувьчлал/	2022.12.14	11.9

### КОМПАНИЙН БОНДЫН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

- Компанийн бондын анхдагч зах зээлийн арилжаа анх 2001 онд явагдсанаас хойш 2022 онд давхардсан тоогоор 18 компани 30 удаагийн арилжаагаар нийт 771.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүлжээ.

Гаргасан компани	Бүртгэсэн огноо	Өрийн хэрэгслийн дүн
"Ард кредит ББСБ" ХК	2022.03.09	7.0
"Инвекор ББСБ" ХК	2022.11.09	20.0

### НЭЭЛТТЭЙ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС /ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР/


- 2022 онд анхдагч зах зээлд 89.9 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оноос 22.5 дахин өссөн байна.

Үнэт цаас гаргагч	Бүртгэсэн огноо	Хугацаа	Хүү	Татан төвлөрүүлсэн дүн*
"Омни актив ТЗК" ХХК	2022.01.12	24 сар	14.5%	5.0
"Симпл ассет" ХХК	2022.06.08	18 сар	15%	50.0
"Бэрс Эй Би Эс актив ТЗК" ХХК	2022.08.10	24 сар	16.8%	10.0
"Нөмөр кредит ассет ТЗК" ХХК	2022.09.21	24 сар	17.5%	10.0
"ЛэндМН актив ТЗК" ХХК	2022.09.21	24 сар	17.0%	4.9
"Бичил Эй Би Эс актив ТЗК" ХХК	2022.11.09	24 сар	17.5%	10.0

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН АРИЛЖАА

2022 онд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн анхдагч зах зээлд 2 хамтын хөрөнгө оруулалтын сан нэгж эрхээ арилжиж нийт 3.9 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оноос 12.2 дахин буурсан байна.


Тайлант хугацаанд хоёрдогч зах зээлд нийт 9.7 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оноос 4.3 хувиар өссөн байна.



## ШИГТГЭЭ

### БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс 2022 оны байдлаар биржийн бус зах зээлд нийт 61 үнэт цаас гаргагчийн 78 компанийн бонд гарсан бөгөөд 946.5 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээд байна. Үүнээс 2022 онд 45 үнэт цаас гаргагчийн 498.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татлаа.




- Дотоодын ААН, 46.8%
- Дотоодын иргэн, 49.6%

### АРИЛЖААНЫ БҮТЭЦ /ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДААР/

- Арилжаанд оролцогчдын дийлэнх хувийг дотоодын иргэн эзэлж байгаа бөгөөд 2022 оны байдлаар дотоодын иргэний хийсэн арилжааны гүйлгээ 49.6 хувийг, дотоодын ААН-ийн хийсэн арилжааны гүйлгээ 46.8 хувийг тус тус эзэлж байна. Харин гадаадын ААН-ийн хийсэн арилжааны гүйлгээ 1.6 хувь, гадаадын иргэний хийсэн арилжааны гүйлгээ 2 хувь байна.

- Гадаадын ААН, 1.6%
- Гадаадын иргэн, 2.0%




- Хувийн өмчит 85.9%
- Төрийн өмчит 11.0%

- Төрийн өмчит оролцоотой 3.1%

### ХУВЬЦААНЫ ӨМЧИЙН БҮТЭЦ

- 2022 оны байдлаар Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны бүртгэлд нийт 318 ХК бүртгэлтэй байна.
- Өмчийн бүтцийг задлан харвал нийт ХК-ийн 85.9 хувь нь хувийн өмчит, 11 хувь нь төрийн өмчит, 3.1 хувь нь төрийн өмчийн оролцоотой байна.

## АШИГТ АЖИЛЛАГАА



## ҮЦК-ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

- ҮЦК-уудын нийт хөрөнгө 2022 онд 189.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 48.5 хувиар өссөн үзүүлэлт юм.
- ҮЦК-уудын үйл ажиллагааны орлого болон хэрэгжээгүй олз 2021 онтой харьцуулахад 55.2 хувиар буюу 19.0 тэрбум төгрөгөөр өсөж 53.4 тэрбум төгрөг болсон.
- ҮЦК-ийн үйл ажиллагааны болон хэрэгжээгүй гарз өмнөх оноос 68.5 хувь буюу 15.0 тэрбум төгрөгөөр тус нэмэгдэж 36.9 тэрбум төгрөгт хүрснээр 16.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.
- Цэвэр ахиуц ашиг 30.9 хувь болсон нь өмнөх оноос 5.1 пунктээр буурчээ.

2.2

тэрбум төгрөг

Нийгмийн даатгалын  
шимтгэл

1.0

тэрбум төгрөг

Орлогын албан  
татвар


0.4

тэрбум төгрөг

Хувь хүний  
орлогын албан  
татвар

- Үнэт цаасны компаниуд 2022 онд НДШ-д 2.2 тэрбум төгрөг, ХХОАТ-т 0.4 тэрбум төгрөг, ААН-ийн орлогын албан татварт 1.0 тэрбум төгрөгийг тус тус төлж, улсын төсөвт 3.6 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд байна.

## ХОМК-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




## ХОМК-ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

- ХОМК-уудын нийт хөрөнгө 2022 онд 68.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 0.3 хувиар өссөн үзүүлэлт юм.
- ХОМК-уудын орлого 2021 онтой харьцуулахад 33.3 хувиар буюу 1.2 тэрбум төгрөгөөр өсөж 4.8 тэрбум төгрөг болсон.
- ХОМК-уудын зардал 29.4 хувь буюу 1.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 6.6 тэрбум төгрөгт хүрснээр 1.8 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.



- Хөрөнгө оруулалт менежментийн компаниуд 2022 онд НДШ-д 0.8 тэрбум төгрөг, ХХОАТ-т 0.3 тэрбум төгрөг, ААН-ийн орлогын албан татварт 0.03 тэрбум төгрөгийг тус тус төлж, улсын төсөвт 1.13 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.


### ХААБ-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



#### ХААБ-ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

- ХААБ-уудын нийт хөрөнгө 2022 онд 6.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 84.8 хувиар өссөн үзүүлэлт юм.
- ХААБ-уудын борлуулалтын орлого 2021 онтой харьцуулахад 3.6 дахин буюу 4.6 тэрбум төгрөгөөр өсөж 6.4 тэрбум төгрөг болсон.
- ХААБ-уудын зардал өмнөх оноос 12.2 дахин буюу 5.6 тэрбум төгрөгөөр өсөж 6.1 тэрбум төгрөгт хүрснээр 0.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.
- Цэвэр ахиуц ашиг 3 хувь болсон нь өмнөх оноос 69 пунктээр буурчээ.

### КАСТОДИОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




#### КАСТОДИОНЫ АШИГТ АЖИЛЛАГАА

- Кастодиан банкны орлого 2021 онтой харьцуулахад 40.0 хувиар буюу 0.2 тэрбум төгрөгөөр өсөж 0.7 тэрбум төгрөг болсон.
- Кастодиан банкны зардал өмнөх оноос 5.0 дахин буюу 0.8 тэрбум төгрөгөөр өсөж 1.0 тэрбум төгрөгт хүрснээр 0.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

## КАСТОДИАНЫ ХАРИЛЦАГЧДЫН БҮТЭЦ

- Кастодиан банкны харилцагчдын дийлэнх хувийг дотоодын иргэн эзэлж байгаа бөгөөд 2022 онд нийт харилцагчдын 92.3 хувийг дотоодын иргэн, 6.2 хувийг дотоодын ААН, 0.8 хувийг гадаадын иргэн, 0.7 хувийг гадаадын ААН тус тус эзэлж байна.




- Кастодиан банканд хадгалагдаж буй хөрөнгийг ангилан үзвэл 99.6 хувийг харилцагчдын эзэмшиж буй үнэт цаас, 0.3 хувийг ХБҮЦ, 0.05 хувийг үл хөдлөх хөрөнгө, 0.05 хувийг мөнгөн хөрөнгө тус тус эзэлж байна.



## ТОГТВОРТОЙ БАЙДАЛ


Хөрөнгийн зах зээлийн хамгийн өндөр үнэлгээгээтэй 5 хувьцаат компани нь нийт зах зээлийн үнэлгээний 57.4 хувийг, хамгийн өндөр үнэлгээтэй 10 компани нь 74.2 хувийг тус тус бүрдүүлж байна.



### ҮЦК-УУДЫН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШИНЖИЛГЭЭ

- 2022 онд үнэт цаасны 52 компанийн эргэлтийн харьцаа 1-ээс их буюу зохистой түвшинд нийт компанийн 88.5 хувь буюу 46 ҮЦК, эргэлтийн харьцаа 1-ээс бага түвшинд 11.5 хувь буюу 6 ҮЦК байна.
- Харин өрийн харьцаа 100 хувиас бага буюу зохистой түвшинд нийт компанийн 98.1 хувь буюу 51 ҮЦК, 100 хувиас их нийт компанийн 1.9 хувь буюу 1 ҮЦК байна.

#### ЭРГЭЛТИЙН БА ӨР ТӨЛБӨР, НИЙТ ХӨРӨНГИЙН ХАРЬЦАА



### ХОМК-ДЫН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШИНЖИЛГЭЭ

- 2022 онд хөрөнгө оруулалт менежментийн 38 компанийн эргэлтийн харьцаа /ЭХ/ 1-ээс их буюу зохистой түвшинд нийт компанийн 60.5 хувь буюу 23 ХОМК, эргэлтийн харьцаа 1-ээс бага түвшинд 39.5 хувь буюу 15 ХОМК байна.
- Харин өрийн харьцаа /ӨТХХ/ 100 хувиас бага буюу зохистой түвшинд нийт компанийн 81.6 хувь буюу 31 ХОМК, 100 хувиас их нийт компанийн 18.4 хувь буюу 7 ХОМК байна.

#### ЭРГЭЛТИЙН БА ӨР ТӨЛБӨР, НИЙТ ХӨРӨНГИЙН ХАРЬЦАА



## БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН



### ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Улсын Их Хурлаас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2022.04.29-ний өдөр баталсан. Тус хуулийн 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах, эрх зүйн орчныг бий болгох хүрээнд “Төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцааг эзэмшихтэй холбоотой хуульд заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавих журам”-ыг, Санхүүгийн зохицуулах хорооны 2022.10.14-ний өдрийн 520 дугаар тогтоолоор баталлаа.
- Улсын Их Хурлаас Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2021 онд баталснаар системийн нөлөө бүхий арилжааны банкнууд нээлттэй хувьцаат компани хэлбэртэй болгох шаардлага тавигдсан. Харин бусад банкнуудын хувьд хувьцаагаа олон нийтэд санал болгон нээлттэй хувьцаат компани болох эсхүл компанийн хэлбэрийг хаалттай хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх нь нээлттэй байхаар хуульчлагдсан бол энэхүү банкны салбарын реформын хүрээнд 3 банк IPO-гоо амжилттай хийсэн. Банкны системд нөлөө бүхий банкнуудын анхдагч зах зээлийн арилжааны захиалгын явцаас харахад хөрөнгө оруулагчид санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, ялангуяа системд нөлөө бүхий банкнуудын хувьцаанд хөрөнгө оруулах эрэлт хэрэгцээ өндөр байгааг харуулсан. Энэ хүрээнд санхүүгийн салбарын мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хамтын хөрөнгө оруулалтын сангуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, банкны салбарын реформын хүрээнд системд нөлөө бүхий банкнуудад хөрөнгө оруулалт хийх бололцоог өсгөх хэрэгцээ, шаардлагын улмаас “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-д нэмэлт, өөрчлөлтийг тусгаж, Санхүүгийн зохицуулах хорооны 2022.10.14-ний өдрийн 521 дүгээр тогтоолоор баталлаа.



### ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022.08.17-ны өдрийн 390 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан хөрөнгийн зах зээлийн бодлогын зөвлөлийн ээлжит хурлыг 2022.11.29-ний өдөр зохион байгуулж, сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлд гарч буй эерэг өөрчлөлтүүдийг хадгалах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх асуудлыг бодлогоор дэмжих хүрээнд татварын эрх зүйн орчин, үнэт цаасны арилжаа, шимтгэл хураамжийн талаар мэдээлэл өгөх зорилго бүхий ажлыг үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын дунд Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой хамтран зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Үүний дагуу “Хөрөнгийн зах зээлд гарч буй бодлого, зохицуулалтын үр нөлөө болон татварын эрх зүйн орчин” сэдэвт хэлэлцүүлгийг 2022.12.06-ны өдөр Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Татварын ерөнхий газартай хамтран зохион байгуулсан. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож, санхүүжилтийн зардлыг бууруулах арга хэмжээний хүрээнд хөрөнгийн зах зээлийн татварын орчныг сайжруулах, шимтгэл хураамжийг бууруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран олон ажлыг авч хэрэгжүүлээд байгаагийн нэг нь тус хэлэлцүүлэг юм.



# ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Нийт хөрөнгө

**474.9** тэрбум төгрөг

Хөрөнгийн өсөлт **11.6%**



Санхүүгийн зах зээлийн төлөв

Даатгалын нягтрал

**87,816** төгрөг

Нягтралын өсөлт  
**19.5%**



Хүртээмжтэй байдал

Зуучилсан даатгалын  
болон давхар даатгалын  
нийт хураамж

**75.0** тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Цэвэр ашиг  
**18.5**  
тэрбум төгрөг

Улсад татан  
төвлөрүүлсэн  
татвар, НДШ

**12.8**  
тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Давхар даатгалд  
төлсөн хураамж

**33.2%**


Бодлого зохицуулалт



## САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ



### ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ

Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн үндсэн дээр нийт 323 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, актуарч, аудитор мөн 2,376 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа эрхэлж байна.



### ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ

- Даатгалын гүнзгийрэлт 0.63 хувьд хүрч өнгөрсөн онтой харьцуулахад 0.05 пунктээр өссөн.




### ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН НИЙТ ХӨРӨНГӨ

- Нийт хөрөнгийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 11.6 хувиар өсөж 474.9 тэрбум төгрөгт хүрсэн бол 2018 онтой харьцуулахад 43.1 хувиар өсжээ.
- Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ бусад даатгалын төрөлтэй харьцуулахад өмнөх оноос 11.1 хувиар өсөж 398.2 тэрбум төгрөгт хүрсэнээр салбарын нийт хөрөнгийн 83.9 хувийг бүрдүүлж байна.
- Урт хугацааны даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 76.3 хувиар өсөж 16.4 тэрбум төгрөгт хүрч, салбарын 3.4 хувийг эзэлж байна.
- Давхар даатгалын компанийн нийт хөрөнгө өмнөх онтой оноос 4.3 хувиар өсөж, 60.3 тэрбум төгрөг хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 12.7 хувийг эзэлж байна.


ХӨРӨНГИЙН БҮТЭЦ БА ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВИЙ /НИЙТ ХӨРӨНГӨӨР/

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн бүтцийг авч үзвэл 21.9 тэрбум төгрөг буюу 4.6 хувийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, 282.2 тэрбум төгрөг буюу 59.4 хувийг хөрөнгө оруулалт, 30.2 тэрбум төгрөг буюу 6.4 хувийг үндсэн ба биет бус хөрөнгө /цэвэр дүн/, 140.6 тэрбум төгрөг буюу 29.6 хувийг бусад хөрөнгө тус тус бүрдүүлж байна.



Даатгалын компаниудыг нийт хөрөнгөд эзэлж буй хувиар нь авч үзвэл 9 хувиас дээш хувийг 2 даатгалын, 6–9 хувийг 6 даатгалын, 3–6 хувийг 3 даатгалын, 3 хувиас доош хувийг 7 даатгалын компани бүрдүүлж байна.


Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь



### ДААТГАЛЫН КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН ӨСӨЛТИЙН ТАРХАЛТ


Нийт даатгалын компаниудын хөрөнгийн дундаж өсөлт 2021 оны байдлаар 6.5 хувь байсан бол тайлант онд 8.6 хувьтай байна. Харин хөрөнгийн өсөлтөөр бүлэглэвэл 30-аас дээш өсөлттэй 1, 20-30 хувийн өсөлттэй 3, 10-20 хувийн өсөлттэй 3, 0-10 хувийн өсөлттэй 5, хөрөнгийн хэмжээ буурсан 5 даатгалын компани байна.

### 2020-2021 / 2021-2022



Жич: 2020 онд үйл ажиллагаа эрхэлж байсан даатгалын компаниудын тоо болон хөрөнгийн хэмжээг суурь болгон тооцсон.

- Erdийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж
- Erdийн болон урт хугацааны даатгалын давхар даатгалын хураамж
- Дотоодын давхар даатгалын компанийн нийт хураамж



### НИЙТ ХУРААМЖ

- Erdийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт 300.7 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлжээ.

Үүнээс: ердийн даатгалын компаниуд 298.0 тэрбум төгрөг буюу 99.1 хувь, урт хугацааны даатгалын компаниуд 2.7 тэрбум төгрөг буюу 0.9 хувийг бүрдүүлжээ.


- Нийт хураамжийг өмнөх онтой харьцуулахад 23.6 хувиар, 2018 онтой харьцуулахад 69.9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

### ДАВХАР ДААТГАЛД ТӨЛСӨН ХУРААМЖ

- Erdийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт хураамжийн орлогын 100.0 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид төлсөн. Үүний 4.1 тэрбум төгрөг буюу 4.1 хувийг дотоодын давхар даатгагчид төлжээ.

## ДААТГАЛЫН БОЛОН ДАВХАР ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

- Даатгалын компаниудын нөхөн төлбөрийн зардал 94.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 36.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин 2018 онтой харьцуулахад 63.3 хувиар өссөн. Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 98.6 хувийг бүрдүүлжээ.
- Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийн дүн 1.8 дахин өсөж 8.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.



### НӨӨЦ САН

- Даатгалын салбарын нөөц сангийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 12.0 хувиар өсөж 216.9 тэрбум төгрөгт хүрсэн.
- Ердийн даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 11.2 хувиар өсөж 182.2 тэрбум төгрөгт хүрсэн бол, урт хугацааны даатгалын компаниудын нөөц сан 20.8 хувиар өсөж 2.9 тэрбум төгрөг, давхар даатгалын компанийн нөөц сан 15.6 хувиар өсөж 31.8 тэрбум төгрөг болов.



216.9

Тэрбум төгрөг  
2022


193.7

Тэрбум төгрөг  
2021

## ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

### ДААТГАЛЫН НЯГТРАЛ

Даатгалын нягтралын үзүүлэлт буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцаа нь салбарын хүртээмж, эрэлтийг илэрхийлдэг.



- Даатгалын нягтрал 2022 онд 87,816 төгрөг болж 2021 онтой харьцуулахад 19.5 хувиар, 2018 онтой харьцуулахад 57.7 хувиар тус тус өссөн байна.
- Даатгалын нягтралыг ангиллаар авч үзвэл, нэг хүнд ногдох ердийн даатгалын хураамж 19.3 хувиар өсөж 87,021 төгрөг болсон бол урт хугацааны даатгалын хураамж 47.0 хувиар өсөж 795 төгрөгт хүрсэн байна.

Жич: Монгол Улсын 2022.12.31-ны байдлаарх нийт хүн амын тоог <https://countrymeters.info/en/Mongolia> сайтаас авсан болно.

### ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ТОО

Тайлант онд нийт 1,343,864 даатгалын гэрээ байгуулагдсан байна. Үүний 82.4 хувь буюу 1,107,286 хувь хүнтэй, 17.6 хувь буюу 236,578 нь хуулийн этгээдтэй байгуулсан даатгалын гэрээ байв.

ХУВЬ ХҮН **1,107,286**

ХУУЛИЙН  
ЭТГЭЭД **236,578**




САЛБАР ТӨЛӨӨЛӨГЧ

Орон нутаг

Даатгалын үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэгч өөр нэгэн үзүүлэлт нь даатгалын компанийн салбар, зуучлагчдын тоо юм. Орон нутагт даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлгээний нийт 1,777 төлөөлөгч, 440 салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байна.

ДААТГАЛЫН КОМПАНИ, ЗУУЧЛАГЧ, ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧДИЙН САЛБАР /БАЙРШЛААР/



ТӨЛӨӨЛӨГЧИД

495

574

482

226

## САЛБАР ТӨЛӨӨЛӨГЧ


Улаанбаатар хот

- Улаанбаатар хотод 297 салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулсан ба үүнээс даатгалын компанийн 48, даатгалын зуучлагчийн 208, хохирол үнэлэгчийн 41 салбар, төлөөлөгчийн газар байна. Эдгээрийг дүүргээр ангилан үзвэл салбар нэгжийн 92.3 хувь нь төвийн 6 дүүрэгт төвлөрчээ.
- Улаанбаатар хотод нийт 599 төлөөлөгч үйл ажиллагаа явуулав.
- Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй даатгалын компанийн төлөөлөгчийн газар 12 байгаагаас БНХАУ–д нэг байна.



	СОНГИНО ХАЙРХАН	ЧИНГЭЛТЭЙ	СҮХБААТАР	БАЯНЗҮРХ
ДААТГАГЧ	4	9	11	5
ЗУУЧЛАГЧ	16	39	47	36
ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	9	4	8	9
	ХАН-УУЛ	БАЯНГОЛ	НАЛАЙХ	БАГАНУУР
ДААТГАГЧ	3	4	3	8
ЗУУЧЛАГЧ	32	28	6	4
ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	3	7	0	1
	БАГАХАНГАЙ			
ДААТГАГЧ	1			
ЗУУЧЛАГЧ	0			
ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	0			

## БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ



- Ердийн болон урт хугацааны даатгалын 23 хэлбэрээс “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал”-аас бусад нь сайн дурын даатгалын хэлбэр юм.
- Давхардсан тоогоор даатгалын бүтээгдэхүүнийг 2021 онтой харьцуулахад 63 бүтээгдэхүүнээр өсөж 687 болов. Энэ нь 2018 онтой харьцуулахад 106 бүтээгдэхүүнээр нэмэгдсэн.
- Эдгээр 687 бүтээгдэхүүнийг даатгалын хэлбэрээр нь ангилан харахад 22.0 хувийг хөрөнгийн даатгал, 21.5 хувийг гэнэтийн осол, эмчилгээний даатгал, мөн 21.8 хувийг хариуцлагын даатгалын хэлбэр тус тус эзэлж байгаа бол үлдсэн 34.7 хувийг бусад 20 даатгалын хэлбэр бүрдүүлж байна.

### Ердийн даатгалын нийт хураамж




### Ердийн даатгалын нөхөн төлбөр



### АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж өмнөх онтой харьцуулахад 9.9 хувиар өсөж 41.0 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт даатгалын хураамжийн орлогын 13.6 хувийг эзэлж байна.
- Нөхөн төлбөр нь өмнөх онтой харьцуулахад 70.6 хувийн өсөлттэй байна. Тайлант онд 31.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь салбарын нийт нөхөн төлбөрийн зардлын 33.9 хувийг бүрдүүлжээ.



### ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИД

- Даатгалын зуучлагчдын төвлөрүүлсэн даатгалын болон давхар даатгалын хураамж 75.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин даатгалын зуучлагчдын зуучлалын шимтгэлийн орлого өмнөх онд 13.6 тэрбум төгрөг байснаас 11.8 хувиар өсөж 15.2 тэрбум төгрөгт хүрэв.


### ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИД

- Даатгалын хохирол үнэлэгч компаниуд 36,999 хохирлыг 47.9 тэрбум төгрөгөөр үнэлэв. Даатгалын хохирол үнэлгээний орлого өмнөх онтой харьцуулахад 87.5 хувиар өсөж 3.0 тэрбум төгрөгт хүрлээ.

## АШИГТ АЖИЛЛАГАА



### ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ЦЭВЭР АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

- Тайлант онд даатгалын компаниудын цэвэр ашиг 2021 оны онтой харьцуулахад 26.6 хувиар буурч 18.5 тэрбум төгрөгт хүрсэн.
- Татварын дараах цэвэр ашгийн өсөлтийг бүлэглэн авч үзвэл цэвэр ашгийн хэмжээ буурсан 5, 50 хувь хүртэлх өсөлттэй 5, 50–100 хувийн өсөлттэй 2, 100 хувиас дээш өсөлттэй 5 даатгалын компани байна.



### ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД

- Хохирол нөхөлтийн харьцаа 2021 онтой харьцуулахад 4.3 пунктээр өсөж 53.9 хувьд хүрэв.
- Тайланд онд зардлын харьцаа 1.4 пунктээр буурч 61.5 хувь болжээ.
- Даатгалын салбарын цэвэр ахиуц ашгийн харьцаа 4.1 пунктээр буурч 6.1 хувьд хүрлээ.



### АШИГТ АЖИЛЛАГААНЫ КОЭФИЦИЕНТ

- Нийт хөрөнгийн өгөөж 1.8 пунктээр буурч 4.0 хувьд хүрсэн бол өөрийн хөрөнгийн өгөөж 3.7 пунктээр буурч 9.0 хувьд хүрэв.

- Даатгалын компаниуд нь 7.6 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлд, 2.5 тэрбум төгрөгийг хувь хүний орлогын албан татварт, 2.7 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварт төлж, нийт 12.8 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## ТОГТВОРТОЙ БАЙДАЛ


## ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

- Даатгалын компаниудын дийлэнх нь гадаад улсад давхар даатгуулдаг бөгөөд сүүлийн гурван жилийн хугацаанд 1 жилд дунджаар 83.7 орчим тэрбум төгрөгийг гадаад улсруу шилжүүлсэн.
- Даатгалын компаниудын гадаад улсад төвлөрүүлсэн давхар даатгалын хураамжийн зардал даатгалын нийт хураамжийн 33.2 хувьтай тэнцэж байна.

33.2%

Давхар даатгалын  
хураамжийн нийт  
хураамжид  
эзлэх хувь

## Давхар даатгалын хураамж




Жич: 1. Давхар даатгалын хураамжийг өссөн дүнгээр тооцсон болно.  
2. Монголбанкны 2022.12.31-ны өдрийн ам.долларын ханш.

- Даатгалын компаниуд нийт хөрөнгийн 59.4 хувь буюу 282.1 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтад байршуулснаас 68.6 хувь нь хадгаламж, хадгаламжийн сертификат, 31.3 хувь нь үнэт цаас, үлдсэн хувь нь хараат ба хамтын хяналттай, охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт хэлбэртэй байна.
- Хадгаламж, хадгаламжийн сертификат болон үнэт цаасны хөрөнгө оруулалтаас даатгалын компаниуд нийт 21.8 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсон байна.

Хөрөнгө  
оруулалтын  
дүн  
59.4%

## Даатгалын нийт хөрөнгө оруулалт ба хадгаламжийн жигнэсэн дундаж хүү



## БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



### ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Монгол Улсын Их Хурлаас 2022.12.23–ны өдөр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Даатгалын тухай хуулиудад даатгагч нь холбогдох этгээдээс бусад этгээдэд баталгаа, батлан даалт гаргах, төрийн худалдан авах ажиллагаанд даатгагчийн баталгааг хүлээн авах боломжийг бүрдүүлсэн нэмэлт өөрчлөлтийг оруулж баталсан.
- 2022 оны 558 дугаар тогтоолоор “Эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тооцсон төлбөрийн чадварын зохистой харьцааны журам”, “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ыг шинэчлэн баталсан. Үүний үр дүнд даатгалын компаниудын үндсэн хэсэг болох эрсдэлийн удирдлагын тогтолцоо сайжрах, оновчтой хэлбэрээр хэрэгжүүлэх, эрсдэлийн үнэлгээний аргачлал олон улсын жишигт нийцэх, даатгагчийн эрсдэлийг илүү бодитой, нарийвчилсан, өөрт тохирсон аргаар тооцоолох боломжийг олгох, хөрөнгө оруулалтын эрсдэлийг тодорхойлж, түүний боломжийг нэмэгдүүлж өгөх болон эрсдэлийг тархах боломж бүрдсэн.



### ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- 2022.11.09–2022.11.11–ний өдрүүдэд Чили улсын Сантьяго хотод зохион байгуулагдсан Даатгалын зохицуулагч байгууллагуудын олон улсын холбооны LAIS/ 2022 оны тайлангийн хуралд оролцов. Тус хуралд гишүүн орнуудын зохицуулалтын байгууллагын 300 гаруй төлөөлөл оролцож үйл ажиллагааны тайланг хэлэлцэхийн сацуу “Өөрчлөгдөж буй нөхцөл байдал: Хөгжиж буй эдийн засаг болон нийгмийн өөрчлөлтөд даатгалын үзүүлэх нөлөө” сэдвийн хүрээнд олон улсын хурал, хэлэлцүүлэг болсон. Тэгш хуваарилалт болон хүртээмжтэй байдал, өөрчлөгдөж буй хэрэглэгчийн чиг хандлага, макро эдийн засаг, цаг агаарын эрсдэл, даатгалын хөрөнгийн шаардлагад тавигдах стандартуудын талаар тусгайлан хэлэлцсэнээс гадна хүртээмжтэй даатгалын зохицуулалтын орчныг сайжруулах замаар даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх талаар Гана, Кени, Коста Рика болон Зимбабве улсуудын салбарын хэлэлцүүлэгт оролцсон.
- БНСУ–ын “Сөүлийн баталгааны даатгал” компанитай хамтран даатгагчийн баталгааны талаар мэдээлэл солилцож улмаар 2022.11.29–ний өдөр “Баталгааны даатгал, эдийн засаг дахь үүрэг оролцоо, хэрэгжүүлэх арга хэлбэр” сургалт, уулзалтыг зохион байгуулсан.
- Азийн орнуудын мэдлэг туршлага солилцох сүлжээ (MEFIN)–нээс 2022.10.18–ны өдөр Хүртээмжтэй даатгалын асуудлаар зохион байгуулагдсан “Заавал даатгал болгох замаар хүртээмжтэй даатгалын зах зээлийг дэмжих: Inkoprit–ийн туршлага” сэдэвт сургалтад Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл хамрагдсан.
- Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн хүрээнд Их Британийн Даатгалын Итгэмжлэгдсэн Институт (CII)–ийн “Ердийн даатгал” сэдэвт 2 удаагийн цахим сургалтад Санхүүгийн зохицуулах хорооны 12 төлөөлөл хамрагдаж байна.



### ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- 2022.10.31–ний өдөр “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”, “Эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тооцсон төлбөрийн чадварын зохистой харьцааны журам”–ын танилцуулга уулзалтыг зохион байгуулсан. Тус уулзалтад даатгалын компаниудын актуарч, нягтлан бодогч, хөрөнгө оруулалтын менежерүүдийн төлөөллүүд тус тус оролцсон.
- Даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийн нэгдсэн хэлэлцүүлгийг 2022.11.25–ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт даатгалын мэргэжлийн холбоод, даатгалын компаниуд болон мэргэжлийн оролцогчдын төлөөлөл хамрагдсан ба хуулийн төслүүдэд иргэд олон нийт, мэргэжлийн оролцогчдоос ирүүлсэн саналууд болон тэдгээрийг тусгасан байдлыг танилцуулсан. Хуулийн төслийг эцсийн байдлаар шинэчлэн 2022 оны Улсын Их Хурлын намрын чуулганд өргөн барих бэлтгэл ажлыг хангасан.
- “Баталгааны даатгал, эдийн засаг дахь үүрэг оролцоо, хэрэгжүүлэх арга хэлбэр” сэдэвт сургалт, уулзалтыг 2022.11.29–ний өдөр зохион байгуулсан. Тус уулзалтад холбогдох төрийн болон хувийн байгууллагын албан хаагчдыг хамруулан “Даатгалын тухай хууль”–д даатгагчийн баталгаатай холбоотой тусгагдсан зохицуулалтын талаар мэдээлэл өгч, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн.
- 2022.12.20–ны өдөр даатгалын компаниудын гүйцэтгэх удирдлагуудыг хамруулан “Даатгагчийн баталгаа, батлан даалт” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тус уулзалтаар Санхүүгийн зохицуулах хорооноос батлан хэрэгжүүлэх журам, даатгалын компаниудын зүгээс даатгагчийн баталгаа хийхтэй холбоотой үйл ажиллагааны ерөнхий зохион байгуулалт зэрэг сэдвүүдээр санал солилцсон.



# БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Нийт хөрөнгө

**3.5**

их наяд төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Хөрөнгийн өсөлт

**30.1%**

Харилцагч

**4.6** сая

Дундаж зээлийн хэмжээ

**2.3** сая төгрөг



Хүртээмжтэй байдал

Зээлийн ББСБ

**93.0%**

Зөвхөн гадаад валютын  
арилжааны ББСБ

**7.0%**



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Нийт орлого

**867.8**

тэрбум төгрөг

Улсад татан  
төвлөрүүлсэн  
татвар, НДШ

**73.8**

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Z индекс

**15.3**

Чанаргүй зээлийн нийт  
зээлд эзлэх хувь

**7.6%**

Бодлого зохицуулалт



## САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

- 2022 онд Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр 513 ББСБ үйл ажиллагаа явуулав. Энэ нь өмнөх оноос 21-ээр буурсан үзүүлэлт юм.





Нийт ББСБ-ын 5.1 хувь нь гадаадын, 94.9 хувь нь үндэсний хөрөнгө оруулалттай байна.



### ББСБ-УУДЫН ХӨРӨНГӨ

2022 онд ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 3.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 817.1 тэрбум төгрөгөөр буюу 30.2 хувиар, 2018 оноос 2.2 их наяд төгрөгөөр буюу 174.5 хувиар өсжээ.




**ББСБ-уудын активын бүтэц /тэрбум төгрөгөөр/**

<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>3,527.0</b>	<b>100.0%</b>
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>3,415.8</b>	<b>96.8%</b>
Мөнгөн хөрөнгө	490.5	13.9%
Зээл /цэврээр/	2,571.2	72.9%
Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	29.1	0.8%
Факторингийн тооцооны авлага /цэврээр/	9.7	0.3%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	24.2	0.7%
Бусад хөрөнгө	291.1	8.2%
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>111.2</b>	<b>3.2%</b>




**ББСБ-уудын пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/**

<b>Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн</b>	<b>3,527.0</b>	<b>100.0%</b>
<b>Өр төлбөр</b>	<b>1,335.4</b>	<b>37.9%</b>
Санхүүгийн эх үүсвэр	381.1	10.8%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	396.8	11.2%
Бусад эх үүсвэр	48.1	1.4%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	228.3	6.5%
Төслийн зээлийн санхүүжилт	30.0	0.9%
Бусад өр төлбөр	251.1	7.1%
<b>Эздийн өмч</b>	<b>2,191.6</b>	<b>62.1%</b>
Хувьцаат капитал	1,275.7	36.2%
Бусад өмч	62.4	1.7%
Сангууд	2.7	0.1%
Хуримтлагдсан ашиг/ алдагдал	774.8	22.0%
Хоёрдогч өглөг	76.0	2.1%



Зах зээлд эзлэх хувь хэмжээ буюу нийт хөрөнгөд эзлэх хувиар нь харвал салбарын нийт хөрөнгийн:

- 25 хувийг хамгийн их хөрөнгө бүхий 4 ББСБ;
- 50 хувийг хамгийн их хөрөнгө бүхий 19 ББСБ;
- 75 хувийг хамгийн их хөрөнгө бүхий 102 ББСБ эзэлж байна.




	ББСБ–ын тоо		Нийт хөрөнгө		Нийт зээл		Зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь	Харилцагчдын тоо	
	Тоо	%	Хэмжээ /тэрбум төг/	%	Хэмжээ /тэрбум төг/	%		Тоо	%
Топ 25 %	4	0.8%	869.1	24.6%	675.6	24.8%	4.9%	113,453	4.3%
Топ 50 %	19	3.7%	1,771.5	50.2%	1,414.1	51.9%	5.1%	4,075,322	87.9%
Топ 75 %	102	19.9%	2,643.3	75.0%	2,106	77.4%	6.5%	4,491,535	96.9%
<b>САЛБАРЫН НИЙТ</b>	<b>513</b>	<b>100.0%</b>	<b>3,527.0</b>	<b>100.0%</b>	<b>2,722.6</b>	<b>100.0%</b>	<b>7.6%</b>	<b>4,633,616</b>	<b>100.0%</b>

Банк бус санхүүгийн зах зээлийн нийт хөрөнгийн 25, 50 болон 75 хувийг бүрдүүлж буй ББСБ–уудын зээлийн үлдэгдэл салбарын нийт зээлийн үлдэгдлийн 24.8, 51.9, болон 77.4 хувийг тус тус эзэлж байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь харгалзан 4.9, 5.1 болон 6.5 хувьтай байна.

Салбарын нийт хөрөнгийн 50 хувийг бүрдүүлж буй 19 ББСБ–уудын зарим нь үйл ажиллагаандаа технологийн дэвшлийг ашиглан, хүртээмжтэй байдлаар үйлчилгээ үзүүлдэг тул нийт харилцагчдын 87.9 хувь нь эдгээр ББСБ–уудын харилцагчид юм.

	ББСБ–ын тоо	Нийт хөрөнгө		Нийт зээл		Харилцагчдын тоо	
		Хэмжээ /тэрбум төг/	%	Хэмжээ /тэрбум төг/	%	Тоо	%
Дотоодын хөрөнгө оруулалт бүхий	487	3,016.6	85.5%	2,312.1	84.9%	4,501,065	97.1%
Гадаадын хөрөнгө оруулалт бүхий	26	510.3	14.5%	410.5	15.1%	132,551	2.9%

Гадаад хөрөнгө оруулалт бүхий ББСБ–уудын 42.3 хувь буюу 11 нь Япон улсын, 26.9 хувь буюу 7 нь БНСУ–ын, 2 нь АНУ–ын, үлдсэн нь ОХУ, Малайз, Хонг Конг, Англи, Канад болон БНХАУ улсын хөрөнгө оруулалттай байна. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ–уудын хувьд салбарын нийт хөрөнгийн 14.5 хувийг эзэмшдэг бөгөөд нийт харилцагчдын 2.9 хувьд үйлчилгээ үзүүлдэг.




2022 оны байдлаар ББСБ–уудын нийт хөрөнгө Монгол Улсын ДНБ–ий 7.3 хувьтай тэнцэхүйц хэмжээнд байна.

Нийт зээл /тэрбум төгрөг/



Зээлийн хүү: ББСБ-уудын олгосон зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 3.1 хувьд хүрч өмнөх оноос 0.4 пунктээр өссөн бол 2018 оноос 0.2 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.



НИЙТ ЗЭЭЛ

Салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оноос 35.3 хувиар буюу 710.4 тэрбум төгрөгөөр, 2018 оноос 213.2 хувиар буюу 1.8 их наяд төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 97.1 хувийг төгрөгийн зээл, үлдсэн 2.9 хувийг валютын зээл эзэлж байна.

97.1%



ХЭВИЙН

88.5%

-2.0%



ХУГАЦАА ХЭТЭРСЭН

3.9%

+1.4%



ЧАНАРГҮЙ

7.6%

+0.6%

4.7 их наяд төгрөг | Олгосон зээл

Төлөгдсөн зээл | 3.9 их наяд төгрөг

Бөөний болон жижиглэн худалдаа



8.3%

8.2%

Барилга



4.1%

4.1%

Уул, уурхайн олборлолт



0.8%

1.1%

Машин, мотоциклийн засвар үйлчилгээ



1.6%

1.3%

Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйлчилгээ



1.3%

1.2%

Боловсруулах үйлдвэр



0.7%

0.6%

Хөдөө аж, ахуй



0.8%

0.6%

Бусад



82.4%

82.9%



88.2%

ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ

91.4%

ОЛГОСОН ЗЭЭЛ

91.5%

ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ



11.8%

8.6%

8.5%

Нийт зээлийн үлдэгдлийн 88.2 хувь нь иргэнд олгосон зээл, 11.8 хувь нь хуулийн этгээдэд олгосон зээл байна.





Олгосон зээл

Төлөгдсөн зээл

## ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ



Олгосон зээлийн 68.7 хувь, төлөгдсөн зээлийн 71.5 хувийг хэрэглээний зориулалттай зээл бүрдүүлж байна.



ББСБ-уудын олгосон зээлийн 22.0 хувийг 1-2.5 жилийн хугацаатай, 18.3 хувийг 6-12 сарын хугацаатай, 24.2 хувийг 1 сар хүртэлх хугацаатай зээл тус тус бүрдүүлж байна.

## ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

Улсын хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 513 ББСБ болон түүний 427 салбар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 81.9 хувь буюу 420 нь Улаанбаатар хотод байна.






Олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)–ээс гаргасан тооцооллын үзүүлэлтээр нийт 21 аймгийн 57.1 хувь буюу 12 аймагт 3 буюу түүнээс дээш тооны ББСБ байна.

1,000 хүн аж ахуй нэгжид ногдох



100,000 хүн амд ногдох



Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 420 ББСБ-ын 34.1 хувь нь Сүхбаатар дүүрэгт, 27.1 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 16.9 хувь нь Баянгол дүүрэгт, 11.2 хувь нь Баянзүрх дүүрэгт, 8.6 хувь нь Хан-Уул дүүрэгт, 1.9 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 0.2 хувь нь Багануур дүүрэгт тус тус байршилтай байна.

#### ББСБ-УУДЫН ХҮРТЭЭМЖ, ГАЗАРЗҮЙН БАЙРШЛААР

- Монгол Улсын хэмжээнд 18–64 насны 100,000 иргэнд 48 ББСБ, 1000 аж ахуйн нэгжид 11 ББСБ ногдож байна.
- Орон нутгийн хэмжээнд уг харьцаанууд нь 24, 10 байгаа бөгөөд бүс нутгийн хувьд төвийн бүс 100,000 иргэнд 31, зүүн бүс 1000 аж ахуй нэгжид 12 ББСБ ногдож байгаагаар ББСБ-ын хүртээмжээр тэргүүлж байна.
- Улаанбаатар хотын хувьд 100,000 иргэнд 77, 1000 аж ахуйн нэгжид 11 ББСБ ногдож байгаа нь хөдөө орон нутгаас хүртээмж сайтай байгааг харуулж байна.

Улсын хэмжээнд  
100,000 хүнд

48  
ББСБ

1,000 аж  
ахуйн нэгжид


11  
ББСБ




ДУНДАЖ ЗЭЭЛ

- 2022 онд Монгол Улсын хэмжээнд ББСБ-аас нэг зээлдэгч дунджаар 2,292.5 мянган төгрөгийн зээл авсан бол орон нутагт энэхүү үзүүлэлт 2,147.6 мянган төгрөг, Улаанбаатар хотын хувьд 2,295.8 мянган төгрөг байна.
- Харин уг үзүүлэлт өмнөх онд улсын хэмжээнд 1.2 сая төгрөг байсан ба тайлант онд ББСБ-ын нэг зээлдэгчид ногдох зээлийн дундаж хэмжээ 1.1 сая төгрөгөөр буюу 1.9 дахин өсжээ. Энэхүү өсөлт нь зээлдэгчийн тоо буурч, зээлийн хэмжээ ихэссэнтэй холбоотой.
- Нийт зээлдэгчдийн тоо 1.2 сая байгаа нь давхардсан тоогоор хөдөлмөрийн насны буюу 18–64 насны 100 хүн тутмын 61 нь ББСБ-аас зээлтэй байна гэсэн үг юм.


ББСБ-ын харилцагчид




ББСБ-ын зээлдэгчид /насны бүлгээр/



ББСБ-ын зээлдэгчид /боловсролын түвшингээр/




ББСБ-ын ажилчид



## БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ


ББСБ-ЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /ДАВХАРДСАН ТООГООР/



### БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО

- ББСБ-уудын нийт орлого 867.8 тэрбум төгрөгт хүрэв.
- Нийт орлогын 98.2 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу хүүгийн болон хүүгийн бус орлого бүрдүүлж байгаагаас 80.9 хувь буюу 701.9 тэрбум төгрөгийг хүүгийн орлого, 17.3 хувь нь буюу 149.9 тэрбум төгрөгийг хүүгийн бус орлого бүрдүүлж байна.

- Хүүгийн орлого
- Хүүгийн бус орлого
- Үндсэн бус үйл ажиллагааны орлого
- Үндсэн үйл ажиллагааны орлого



### ХҮҮГИЙН БУС ОРЛОГЫН ЗАДАРГАА

- Хүүгийн бус орлогын 45.1 хувийг үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого, 21.5 хувийг ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого, 23.2 хувийг арилжааны орлого, 1.8 хувийг мөнгөн гуйвуулгын орлого, 8.4 хувийг бусад орлого тус тус бүрдүүлж байна.


### БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ

- Нийт зардлын 90.1 хувь нь үндсэн үйл ажиллагааны зардал, 1.5 хувь нь үндсэн бус үйл ажиллагааны зардал, 8.4 хувь нь орлогын албан татварын зардлаас бүрдэж байна.
- Үндсэн үйл ажиллагааны зардлын бүрэлдэхүүн болох хүүгийн зардал нь нийт зардлын 17.2 хувь, хүүгийн бус зардал нь 60.4 хувь, болзошгүй эрсдэлийн зардал 12.5 хувийг бүрдүүлж байна.

Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэлтэй холбоотой гарах зардал буюу болзошгүй эрсдэлийн зардлын хувьд нийт 69.1 тэрбум төгрөг ба үүний 91.4 хувийг зээлийн эрсдэлийн зардал, 5.2 хувийг өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн зардал, 3.4 хувийг авлагын эрсдэлийн зардал бүрдүүлж байна.


- Зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах, энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүхэлд нь хариуцах факторингийн үйл ажиллагаа 2022 оны байдлаар салбарын хэмжээнд нийт 9.7 тэрбум төгрөгийн факторингийн цэвэр авлага бүртгэлтэй байна.

Факторингийн үйлчилгээний цэвэр авлага /тэрбум төгрөг/




- Салбарын хэмжээнд нийт 64 ББСБ итгэлцлийн үйлчилгээг эрхэлж байна.
- Тэдгээрийн үзүүлсэн итгэлцлийн үйлчилгээний нийт өглөг 381.1 тэрбум төгрөг байгаа ба өмнөх оноос 54.4 хувиар өслөө.

Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөг/



Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний орлого /тэрбум төгрөг/



- 2022 оны байдлаар 37 ББСБ мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл эзэмшиж байгаагаас 11 нь 2.7 тэрбум төгрөгийн орлогыг олжээ. Энэ нь өмнөх оноос 5.0 хувь өссөн үзүүлэлт юм.

### ХУДАЛДСАН, ХУДАЛДАН АВСАН ВАЛЮТЫН МЭДЭЭ

ББСБ-ууд нийт 4,833.7 тэрбум төгрөгийн валют худалдан авч, 5,037.1 тэрбум төгрөгийн валютыг худалдсан байна. Худалдаж авсан валютын 43.0 хувийг, худалдсан валютын 41.3 хувийг АНУ-ын доллар бүрдүүлж байна.

ВАЛЮТЫН НЭР	Худалдаж авсан	Худалдсан
	Дүн /тэрбум төгрөг/	Дүн /тэрбум төгрөг/
АНУ-ЫН ДОЛЛАР	2,076.5	2,079.3
БНХАУ-ЫН ЮАНЬ	2,094.2	2,211.7
ЕВРО	308.2	360.6
БНСУ-ЫН ВОН	39.3	41.0
ЯПОНЫ ИЕН	179.2	178.5
БУСАД	136.3	166.0

## ФИНТЕК

**37** ББСБ

**7** Зөвхөн технологид суурилсан

**30** Технологи + Уламжлалт



- Салбарын нийт харилцагчдын 94.2 хувь нь эдгээр ББСБ-ын харилцагчид буюу технологид суурилсан зээлийн үйлчилгээг хүртэх боломжтой.
- Нийт зээлдэгчдийн 78.8 хувь нь зөвхөн гар утсаараа дамжуулан зээл авч байна.

○ Санхүүгийн үйлчилгээнд технологийн дэвшил ашиглаж буй ББСБ-уудын зээлийн үлдэгдлийн 90.0 хувийг хэвийн зээл, 3.6 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 6.4 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлээ.

94.2%



Зээлийн үлдэгдэл

4.4%

Олгосон зээл

16.9%

Төлөгдсөн зээл

18.6%



**90.0%** Хэвийн



**3.6%** Хугацаа хэтэрсэн зээл

**6.4%** Чанаргүй

Зөвхөн технологид суурилсан зээл олгодог ББСБ-уудын хувьд салбарын нийт зээлийн үлдэгдэлд бага хувь эзэлж байгаа ч олгосон болон төлөгдсөн зээлд эзлэх хувиас харахад эдгээр ББСБ-уудын зээл эргэлт сайн байна.


	Нийт зээл		Зээлдэгчийн тоо		1 зээлдэгчид ногдох дундаж зээлийн хэмжээ /мян. төгрөг/
	Хэмжээ /тэрбум төгрөг/	%	Тоо	%	
Финтек	461.0	16.9%	935,975	78.8%	492.6
Уламжлалт	2,261.6	83.1%	251,628	21.2%	8,987.9
<b>НИЙТ</b>	<b>2,722.6</b>	<b>100.0%</b>	<b>1,187,603</b>	<b>100.0%</b>	<b>2,292.5</b>

## АШИГТ АЖИЛЛАГАА



ROE болон ROA-ийн харгалзах интервал дахь ББСБ-ын тоо /хувиар/

(\* ) Жишээ нь: Нийт ББСБ-уудын 21.0 хувь нь 1.0 хувиас доош өөрийн хөрөнгийн өгөөжтэй ажиллаж байна



**НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖИЙН ХАРЬЦАА /ХӨРӨНГИЙН АНГИЛЛААР/**

ББСБ-уудын нийт болон өөрийн хөрөнгийн өгөөжийг хувь нийлүүлсэн хөрөнгийн ангиллаар харахад 1.0 тэрбумаас доош хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ-уудын тал хувь нь 2.2 хувиас бага, 1.0–2.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ-уудын тал хувь нь 6.5 хувиас бага, 2.5 тэрбум төгрөгөөс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ-уудын тал хувь нь 14.8 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй байна. Өөрийн хөрөнгийн өгөөжийн хувьд холбогдох утгууд нь харгалзан 1.7, 7.2 болон 21.2 хувьтай байна.

**ЗАРДАЛ, ОРЛОГЫН ХАРЬЦАА**


Зардал, орлогын харьцаа: ББСБ-ууд нэг төгрөгийн орлого олохын тулд дунджаар хэдэн төгрөгийн зардал гаргаж буйг тооцоход тайлант онд 49.6 хувь гарсан буюу өмнөх оноос 3.3 пунктээр өсчээ. Өөрөөр хэлбэл ББСБ-ууд 100.0 төгрөгийн орлого олохын тулд дунджаар 49.6 төгрөгийн зардал гаргаж байна гэсэн үг юм.



- Нийт ББСБ-ууд нь 2022 онд НДШ-д 20.5 тэрбум төгрөг, ХХОАТ-т 6.5 тэрбум төгрөг, ААН-ийн орлогын албан татварт 46.8 тэрбум төгрөгийг тус тус төлж, нийт улсын төсөвт 73.8 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд байна.

## ТОГТВОРТОЙ БАЙДАЛ


- o AFI –с санхүүгийн хүртээмж болон санхүүгийн тогтвортой байдлыг тодорхойлох зөвлөмж зааврын дагуу ББСБ–уудын дараах 4 үзүүлэлтийг тооцож байна. Үүнд:



### ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХАРЬЦАА


- o Тайлант онд уг харьцаа 105.4 хувь гарч байгуулвал зохих эрсдэлийн санг бүрдүүлж чадсан бөгөөд эрсдэлийг 105.4 хувиар нөхөх чадамжтайг харуулжээ.
- o Энэ нь өмнөх оноос 2.8 пунктээр өссөн үзүүлэлт юм.

**105.4%**




### ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ

Тайлант онд чанаргүй зээлийн хэмжээ 207.0 тэрбум төгрөгт хүрч нийт зээлд эзлэх чанаргүй зээл 7.6 хувь болсон нь өмнөх оноос 0.6 пунктээр өссөн байна.




### МӨНГӨН ХӨРӨНГИЙГ НИЙТ ХӨРӨНГӨД ХАРЬЦУУЛСАН ХАРЬЦАА

Мөнгөн хөрөнгийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа тайлант онд 13.9 хувь болж өмнөх оноос 2.0 пунктээр буурсан байна.



### Z ИНДЕКС

Z индекс нь ББСБ-ын дампуурах магадлалыг харуулдаг ба активын өгөөж болон өөрийн хөрөнгийн харьцааны нийлбэрийг активын өгөөжийн хэлбэлзэлд харьцуулж тооцдог. Z индексийн утга ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хөшүүрэг өндөр байх үед их гарах ба өгөөжийн хэлбэлзэл ихтэй үед буюу орлогын тодорхойгүй байдал их үед бага гарна. Өөрөөр хэлбэл индексийн их утга нь эрсдэл багатай, тогтвортой байдлыг илэрхийлдэг. 2022 оны байдлаар банк бус санхүүгийн салбарын Z индекс өмнөх оноос 10.2 нэгжээр буурч 15.3 боллоо.



## БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



### ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт мөрдөгдөх дүрэм, журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээний хүрээнд дараах хууль, дүрэм журмуудыг шинэчлэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэв.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2022.02.23–ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээр Банк бус санхүүгийн байгууллагуудаас хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх хүсэлт хүлээн авах хугацааг 2022.03.30–ны өдрийг хүртэл хугацаанд сунгасан.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2022.04.06–ны өдрийн 160 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”–ыг баталсан.
- Улсын их хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2022.05.10–ны өдрийн хуралдаанаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж Улсын их хурлын 2022.05.19–ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхийг дэмжиж, хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шилжүүлсэн. Эдийн засгийн байнгын хорооны 2022.05.31–ний өдрийн 06 дугаар тогтоолоор тус хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаад байна.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2022.05.25–ны өдрийн 287 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагын эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын журам”–д нэмэлт өөрчлөлт оруулж батлав.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2022.06.22–ны өдрийн 362 дугаар тогтоолоор Финтек зээлийн үйлчилгээ эрхэлж буй ББСБ–уудыг бүртгэх хугацааг 2022.12.31–ний өдөр хүртэл сунгав.
- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022.09.27–ны өдрийн 434 дүгээр тушаалаар Цахим зөвлөлийн дүрэм батлав.
- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022.09.27–ны өдрийн 433 дугаар тушаалаар Цахим зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгуулав.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2022.10.14–ний өдрийн 527 тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагаас олгох финтек зээлийн бүтээгдэхүүнд тооцох өр, орлогын харьцаа тогтоох тухай” зохицуулалтыг баталсан бөгөөд өр, орлогын харьцааг 70 хувиас хэтрүүлэхгүй байхаар тогтоосон.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2022.10.14–ний өдрийн 526 тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар” баталсан.

#### **“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт**

2022 оны байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4–т заасны дагуу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 90.6 хувь буюу 454 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 84.4 хувь буюу 423 ББСБ хэрэгжүүлсэн байна.

#### **“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт**

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020.03.03–ны өдрийн А–57 дугаар тушаалаар “Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журам”–ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах ажлыг зохион байгуулснаар зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 477 ББСБ–ын 89.3 хувь буюу 426 ББСБ гэрээгээ шинэчлэн байгуулсан байна.

#### **“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1–д заасны дагуу нэр бүхий 133 ББСБ, 15,981 удаагийн тохиолдлоор, 1.1 их наяд төгрөгийг, мөн зүйлийн 7.2–т заасны дагуу нэр бүхий 9 ББСБ, 33 удаагийн тохиолдлоор, 865.6 сая төгрөгийг Монголбанкны СМА–нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

#### **“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”–ын хэрэгжилт**

2022 оны байдлаар нийт 501 ББСБ–аас 1,224.5 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 98.5 хувь буюу 497 ББСБ 1,206.1 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн.



## ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Санхүүгийн зохицуулах хороо нь банк бус санхүүгийн байгууллагын салбарын бодлого зохицуулалтын чиглэлээр дараах олон улсын байгууллага, холбоодтой хамтран ажиллаж байна.

- Санхүүгийн зохицуулах хороо, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадвар судалгааны төвтэй хамтран “Бичил санхүүгийн зах зээлд хүйсийн тэгш оролцоог дэмжих зорилготой хамтын ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулав.
- ТоС Холбоо –той хамтран Санхүүгийн байгууллагуудад зориулсан жишиг байгаль орчин нийгэм засаглалын удирдлага (БОНЗУ)–ын журмын төслийг боловсруулав.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, БОАЖЯам, Монголын тогтвортой санхүүгийн холбоо, Сангийн яам, Монголбанктай хамтран “Ногоон хөгжлийн сэргэлт–Ногоон санхүүжилт” сэдвийн хүрээнд 2022.03.29,30–ны өдрүүдэд бүс нутгийн чуулган зохион байгуулж үндэсний тогтвортой замын зургийг баталж, Санхүүгийн байгууллагуудад уур амьсгалын өөрчлөлтийн стратеги, бодлогыг нэвтрүүлэх боломж, сорилт хамтын ажиллагааг хэлэлцэв.
- ОУСК–тай хамтран хэрэгжүүлж буй Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төслийн хүрээнд ББСБ–ын үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд чиглэсэн Байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээний тогтолцоог боловсрууллаа.
- Азийн хөгжлийн банк (АХБ)–тай хамтран 2022 оны 08 дугаар сараас эхлэн хэрэгжүүлэх Финтекийн хууль эрх зүй, зохицуулалтын орчныг хөгжүүлэх (Developing Fintech Legal and Regulatory Frameworks for Mongolia) төслийн баримт бичиг, санамж бичгийн төслийг эцэслэх уулзалтыг 2022.08.04–ний өдөр цахимаар зохион байгуулав.
- Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /AFI/, Йорданы Төв банктай 2022.09.05–08–ны өдрүүдэд хамтран зохион байгуулсан “Уян хатан, хүртээмжтэй, тогтвортой ирээдүй рүү хамтдаа” Дэлхийн бодлогын форумд Монгол Улсыг төлөөлж Санхүүгийн зохицуулах хорооноос оролцов. Энэ удаагийн форумд дэлхийн 80 гаруй орны 500 гаруй санхүүгийн зохицуулагч байгууллага, төв банкны төлөөлөл болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөгчид оролцож “Ковид–19” ба дэлхийн санхүү, эдийн засгийн нөхцөл байдал цаашилбал цар тахлын дараах санхүүгийн үйлчилгээг илүү хүртээмжтэй, нээлттэй болгоход чиглэсэн бодлого, түүнийг үр өгөөжтэй хэрэгжүүлэх гарц, шийдлийн талаар хэлэлцсэн юм. “Хүртээмжтэй ногоон санхүүжилт” ажлын хэсгийн хурлаар Санхүүгийн зохицуулах хороог төлөөлж санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилт, тулгамдаж буй асуудал, түүний шийдэл, сайн туршлагын талаар байр сууриа илэрхийлж, санал солилцсон бөгөөд Ногоон санхүүгийн замын зургийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж байна.
- Европын сэргээн босголт хөгжлийн банктай хамтран Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг 2022.10.31–ний өдөр зохион байгуулав.



# ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Нийт хөрөнгө

**267.7** тэрбум төгрөг

Хөрөнгийн өсөлт **-8.1%**



Санхүүгийн зах зээлийн төлөв

Нийт салбар **61**

Нийт гишүүдийн тоо

**71,657**



Хүртээмжтэй байдал

Хэрэглээ болон цалин тэтгэвэр,  
хадгаламж барьцаалсан  
зээлийн олгосон зээл

**27.9%**



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Цэвэр ашиг

**11.6**

тэрбум төгрөг

Улсад татан  
төвлөрүүлсэн  
татвар, НДС

**3.5**

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Нийт зээлд эзлэх чанаргүй  
зээлийн хувь

**3.4%**


Бодлого зохицуулалт



## САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

### ХЗХ–ДЫН ТОО БА ГИШҮҮД

- 2022 оны байдлаар тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ–дын тоо өмнөх онтой харьцуулахад 13–аар буюу 6.2 хувиар буурч 196 хүрсэн.
- ХЗХ–дын гишүүдийн тоо 2021 онд 75,400 байсан бол тайлант онд 5.0 хувиар буурч 71,657 гишүүдтэй болжээ.
- ХЗХ–дын тоо 2018 онд 279 байсан бол тайлант жилд 29.7 хувиар буурсан. Харин ХЗХ–дын гишүүдийн тоо 2018 онд 62,556 байсан бол 2022 онд 14.5 хувиар өсжээ.



## АЖИЛЛАГСАД

# 762

ХЗХ–дын нийт ажилтнуудын тоо 762 хүрч өнгөрсөн оноос 2.8 хувиар өссөн бөгөөд түүний 66.9 хувь нь эмэгтэй ажиллагсад байна.

### НИЙТ ГИШҮҮДИЙН


# 32,424

ЗЭЭЛДЭГЧ

# 38,540

ХАДГАЛАМЖ  
ЭЗЭМШИГЧ

■ Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/ ○ Нийт хөрөнгийн өсөлт /хувь/



### НИЙТ ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ ӨСӨЛТ

- Тайлант онд нийт хөрөнгө өмнөх оноос –8.1 хувиар буурч 267.7 тэрбум төгрөгт хүрлээ.
- Тайлант үеийг 2018 онтой харьцуулахад ХЗХ–ны нийт хөрөнгийн дүн 67.5 тэрбум төгрөгөөр буюу 33.7 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

НИЙТ ЗЭЭЛ

# 210.2

ТЭРБУМ ТӨГРӨГ

НИЙТ  
ХАДГАЛАМЖ

# 187.5

ТЭРБУМ ТӨГРӨГ


## НИЙТ ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

- 86.8 хувийг 1.0 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 29 ХЗХ;
- 5.8 хувийг 500.0 саяас 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй 22 ХЗХ;
- 7.4 хувийг 500.0 сая төгрөгөөс доош хөрөнгөтэй 145 ХЗХ эзэлж байна.




## ХЗХ-дын актив болон пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/

<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>267.7</b>	<b>100.0%</b>
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>263.6</b>	<b>98.5%</b>
Мөнгөн хөрөнгө	40.0	14.9%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	0.6	0.2%
Зээл /цэврээр/	205.0	76.6%
Авлага	15.8	5.9%
Бусад эргэлтийн хөрөнгө	1.3	0.5%
Өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	0.9	0.4%
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>4.1</b>	<b>1.5%</b>
Үндсэн хөрөнгө /цэврээр/	3.9	1.4%
Биет бус хөрөнгө /цэврээр/	0.2	0.1%
Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.0%
<b>Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн</b>	<b>267.7</b>	<b>100.0%</b>
<b>Өр төлбөр</b>	<b>207.9</b>	<b>77.7%</b>
Хадгаламж	187.5	70.0%
Богино хугацаат зээл	2.6	1.0%
Бусад богино хугацаат өр төлбөр	14.7	5.5%
Урт хугацаат өр төлбөр	3.1	1.2%
<b>Өөрийн хөрөнгө</b>	<b>59.8</b>	<b>22.3%</b>
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	25.9	9.6%
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.2	0.1%
Хоршоологчдын өмч	33.7	12.6%



- Нийт хөрөнгийн 98.5 хувь нь эргэлтийн хөрөнгө, үлдсэн 1.5 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байна.
- Нийт хөрөнгийн 14.9 хувийг мөнгөн хөрөнгө, 76.6 хувийг цэвэр зээлийн үлдэгдэл, 5.9 хувийг авлагын үлдэгдэл бүрдүүлж байна.
- Эх үүсвэрийн 77.7 хувийг өр төлбөр, 22.3 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

## ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ



## БАРУУН БҮС

40 ХЗХ

8 САЛБАР

## ХАНГАЙН БҮС

19 ХЗХ

18 САЛБАР

## ТӨВИЙН БҮС

21 ХЗХ

20 САЛБАР

## ЗҮҮН БҮС

9 ХЗХ

11 САЛБАР

## УЛААНБААТАР

107 ХЗХ

4 САЛБАР

- Тайлант онд нийт 196 ХЗХ-оос 107 ХЗХ нь Улаанбаатар хотод, 89 ХЗХ нь хөдөө, орон нутагт бүртгэлтэй байна.
- Хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын 44.9 хувь нь баруун бүсэд, 10.1 хувь нь зүүн бүсэд, 21.4 хувь нь хангайн бүсэд, 23.6 хувь нь төвийн бүсэд байршжээ.
- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 107 ХЗХ-ны 95.3 хувь нь төвийн зургаан дүүрэгт, 4.7 хувь нь алслагдмал хоёр дүүрэгт байршиж байна.




АFI-с улс орнуудын санхүүгийн хүртээмжийг үнэлэх үндсэн индикаторуудыг<sup>1</sup> 2013 онд гаргасан. Тус индикаторуудыг ашиглан салбарын хүртээмжтэй байдлыг дараах үзүүлэлтээр илэрхийлсэн. Үүнд хөдөлмөрийн насны буюу 18-аас 64 насны 10,000 хүнд ногдох, 1,000 аж ахуйн нэгж (ААН)-д ногдох ХЗХ-дын тоогоор илэрхийлэх болно.

10 000 хүнд ногдох ХЗХ-ны тоо



1 000 ААН-д ногдох ХЗХ-ны тоо



- 1,000 ААН-д ногдох ХЗХ-ны тоогоор Налайх дүүрэг 5.0, Багануур 4.8, Чингэлтэй дүүрэг 3.1, Сүхбаатар дүүрэг 2.5 үзүүлэлтэйгээр тус тус тэргүүлж байгаа бол Баянгол дүүрэг 0.9 гэсэн үзүүлэлттэйгээр хамгийн доогуур жагсаж байна.
- Харин 10,000 хүнд ногдох ХЗХ-ны тоогоор Сүхбаатар, Чингэлтэй, Налайх дүүргүүд тус тус 3.2, 2.2, 1.3 гэсэн үзүүлэлтээр тэргүүлж байна.

<sup>1</sup> <https://www.afi-global.org/sites/default/files/publications/fidwg-core-set-measuring-fi.pdf>



Хүртээмжийн үзүүлэлтийг 4 бүсээр ангилахад баруун бүс 10,000 хүнд ногдох, 1,000 ААН-д ногдох ХЗХ-дын тоогоор бусад бүсээс сайн үзүүлэлттэй байна.

### Нэг гишүүнд ногдож буй дундаж зээл



### ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18-аас 64 насны 60 хүн тутмын нэг нь ХЗХ-нд гишүүнчлэлтэй, зээлийн үйлчилгээг хүртэж байна.
- Дээрх үзүүлэлт нь хөдөө, орон нутагт 67 хүн тутмын нэг байгаа бол Улаанбаатар хотын хэмжээнд 54 хүнд нэг тохиож байна.
- Улсын хэмжээнд ХЗХ-ноос зээл авсан нэг зээлдэгч гишүүн дунджаар 6.5 сая төгрөгийн зээлтэй байна.
- Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 9.6 сая төгрөг байгаа бол хөдөө, орон нутагт 3.0 сая төгрөг байна.




### ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18-аас 64 насны 50 хүн тутмын нэг нь ХЗХ-нд хадгаламжийн үйлчилгээг хүртэж байна.
- Дээрх үзүүлэлт хөдөө, орон нутагт 56 хүнд нэг байгаа бол Улаанбаатар хотын хэмжээнд 45 хүнд нэг тохиож байна.
- Улсын хэмжээнд ХЗХ-нд хадгаламжтай нэг хадгаламж эзэмшигч гишүүн дунджаар 4.9 сая төгрөгийн хадгаламжтай байна.
- Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 7.5 сая төгрөг байгаа бол хөдөө, орон нутагт 2.1 сая төгрөг байна.

### Нэг гишүүнд ногдож буй хадгаламжийн дундаж хэмжээ




ХЗХ-НЫ ГИШҮҮДИЙН ХҮРТЭЭМЖ



## БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

### ХЗХ-ДЫН ЗЭЭЛ

- Тайлант онд нийт зээлийн хэмжээ 210.2 тэрбум төгрөг болж өмнөх оноос 1.5 хувиар буурлаа.
- Цэвэр зээлийн хэмжээ өмнөх оноос 1.4 хувиар буурч 205.0 тэрбум төгрөгт, зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 5.7 хувиар буурч 5.3 тэрбум төгрөгт хүрлээ.
- Тайлант үеийг 2018 онтой харьцуулахад ХЗХ-ны нийт зээлийн үлдэгдлийн дүн 76.4 тэрбум төгрөгөөр буюу 57.1 хувиар нэмэгдсэн.



ХЭВИЙН

93.8%



ХУГАЦАА ХЭТЭРСЭН

2.8%



ЧАНАРГҮЙ

3.4%

### ХЗХ-ДЫН ЗЭЭЛИЙН ЧАНАР

- Тайлант онд хэвийн зээлийн хэмжээ өмнөх оноос 2.4 хувиар буурч 197.3 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нийт зээлийн 93.8 хувийг хэвийн зээл эзэлж байна.
- Хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өмнөх оноос 52.0 хувиар өсөж 5.9 тэрбум төгрөгт хүрлээ.
- Чанаргүй зээлийн хэмжээ 4.7 хувиар буурч 7.0 тэрбум төгрөгт хүрлээ.
- Тайлант оныг 2018 онтой харьцуулахад ХЗХ-ны салбарын нийт чанаргүй зээлийн дүн 1.1 тэрбум төгрөгөөр буюу 18.1 хувиар нэмэгдсэн.

### ХЗХ-ДЫН ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

- Нийт олгосон зээлийн 27.9 хувь нь хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан, 8.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 3.7 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 50.0 хувь нь бусад зориулалтаар олгогдсон байна.
- Нийт эргэн төлөгдсөн зээлийн 27.6 хувь нь хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан, 7.4 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдааны үйл ажиллагаанаас, 3.7 хувь нь хөдөө аж ахуйн салбараас, 53.3 хувь нь бусад зээлээс эргэн төлөгдсөн байна.

ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ

ОЛГОСОН ЗЭЭЛ

Хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл



27.6% 27.9%

Бөөний, жижиглэн худалдаа



7.4% 8.3%

Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа



0.4% 0.4%

ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур



3.2% 3.7%

Санхүүгийн, даатгалын үйл ажиллагаа



2.7% 3.8%

Барилга



2.4% 2.5%

Машин мотоциклийн засвар үйлчилгээ



1.1% 1.2%

Боловсруулах үйлдвэр



0.6% 0.8%

Байр орон сууц, хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа




1.3% 1.4%

Бусад



53.3% 50.0%

■ Нийт хадгаламж /тэрбум төгрөг/ ○ Хадгаламжийн өсөлт /хувь/



ХЗХ-ДЫН ХАДГАЛАМЖ

- ХЗХ-дын нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оноос 7.9 хувиар буурч 187.5 тэрбум төгрөг боллоо.
- Тайлант оныг 2018 онтой харьцуулахад ХЗХ-ны нийт хадгаламжийн хэмжээ 46.0 тэрбум төгрөгөөр буюу 32.5 хувиар нэмэгдсэн.

НИЙТ ХАДГАЛАМЖ

- 98.5 хувийг хугацаатай хадгаламж, 1.5 хувийг хугацаагүй хадгаламж бүрдүүлж байна.



98.5%

ХУГАЦААТАЙ



1.5%

ХУГАЦААГҮЙ




192 ХЗХ



4 ХЗХ

- Тайлант онд ХЗХ-дын 98.0 хувь буюу 192 ХЗХ нь нийт 187.5 тэрбум төгрөгийн хадгаламж төвлөрүүлсэн.
- Үлдсэн 2.0 хувь буюу 4 ХЗХ хадгаламж татаагүй байна.



#### НИЙТ ХАДГАЛАМЖИД ЭЗЛЭХ ХУВЬ

- 1.0 тэрбумаас дээш төгрөгийн хадгаламжтай 20 ХЗХ нь нийт 162.0 тэрбум төгрөг буюу салбарын нийт хадгаламжийн 86.4 хувийг;
- 10.0 саяас 1.0 тэрбум төгрөгийн хадгаламжтай 152 ХЗХ нь нийт 25.4 тэрбум төгрөг буюу салбарын нийт хадгаламжийн 13.5 хувийг;
- 10.0 саяас доош төгрөгийн хадгаламжтай 20 ХЗХ нь нийт 0.1 тэрбум төгрөг буюу салбарын нийт хадгаламжийн 0.1 хувийг тус тус бүрдүүлж байна.
- Огт хадгаламж татаагүй 4 ХЗХ байна.



1.2%

Хадгаламжийн жигнэсэн  
дундаж сарын хүү



2.3%

Зээлийн жигнэсэн  
дундаж сарын хүү

	2021.II	2021.III	2021.IV	2022.I	2022.II	2022.III	2022.IV
ЗЖДХ	2.5	2.2	2.2	2.1	2.1	2.4	2.3
ХЖДХ	1.4	1.4	1.2	1.1	1.2	1.2	1.2

## ОРЛОГО

ХЗХ–дын хүүгийн орлого өнгөрсөн онтой харьцуулахад 3.1 хувиар өсөж 55.9 тэрбум төгрөгт хүрлээ. Хүүгийн орлогод:

- Нийт хүүгийн орлогын 95.09 хувь буюу 53.5 тэрбум төгрөгийг зээлийн хүүгийн орлого эзэлж байна.
- Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого 4.38 хувийг, зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого 0.49 хувь, санхүүгийн түрээсийн хүүгийн орлого 0.02 хувь, үнэт цаасны хүүгийн орлого 0.02 хувийг тус тус эзэлж байна.



## ЗАРДАЛ

ХЗХ–дын нийт хүүгийн зардал өнгөрсөн онтой харьцуулахад 5.3 хувиар буурч 30.2 тэрбум төгрөгт хүрлээ. Хүүгийн зардалд:



- Хадгаламжийн хүүгийн зардал 97.3 хувь буюу 29.4 тэрбум төгрөг,
- Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүү 2.6 хувь буюу 786.7 сая төгрөг.
- Бусад хүүгийн зардал 36.9 сая төгрөг буюу 0.1 хувийг тус тус эзэлж байна.



## АШИГТ АЖИЛЛАГАА

### ХЗХ-ДЫН ОРЛОГО, ЗАРДАЛ

- Тайлант онд ХЗХ-ны салбар нийт 58.9 тэрбум төгрөгийн орлого, 47.3 тэрбум төгрөгийн зардал, 11.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан.
- Цэвэр ашгийн нийт орлогод эзлэх хувь өмнөх оноос 1.2 пунктээр өсөж 19.7 хувьд хүрчээ.



### НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ


- ХЗХ-дын өөрийн хөрөнгийн өгөөж нь өмнөх онтой харьцуулахад 2.6 пунктээр өсөж 19.4 хувьд хүрлээ.
- Нийт хөрөнгийн өгөөж нь 0.6 пунктээр өсөж 4.3 хувьд хүрчээ.



- ХЗХ-д тайлант онд НДШ-д 1.8 тэрбум төгрөг, ХАОАТ-т 0.5 тэрбум төгрөг, ААНОАТ-т 1.2 тэрбум төгрөг тус тус төлж, нийт улсын төсөвт 3.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд байна.


**ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД**

- Тайлант онд хүүгийн орлогын нийт зээлд эзлэх хувь өмнөх оноос 1.2 пунктээр өсөж 26.6 хувьд хүрлээ.
- Цэвэр орлогыг нийт орлогод харьцуулан тооцдог цэвэр ахиуц ашгийн харьцаа нь өмнөх оноос 1.2 пунктээр өсөж 19.7 хувь болжээ.



**ЗАРДАЛ ОРЛОГЫН ХАРЬЦАА**

- ХЗХ-дын 100.0 төгрөгийн орлого тутмын 24.1 төгрөг нь үйл ажиллагааны зардалд ногдож байна.




## ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ХЗХ нь өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг дараах үндсэн 4 үзүүлэлт /PEARLS аргачлал/-ийн дагуу тооцож, мөрдлөг болгон ажилладаг. Үүнд:

1. Хөрөнгийн чанарын болон хамгаалалтын үзүүлэлт;
2. Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт;
3. Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлт;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт.

■ Чанаргүй зээл /тэрбум төгрөг/    ○ Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь




### ХЗХ-ДЫН ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ

- Нийт чанаргүй зээлийн дүн өнгөрсөн оноос 0.3 тэрбум төгрөгөөр буурч 7.0 тэрбум төгрөг боллоо.
- Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оноос 0.1 пунктээр буурч 3.4 хувьд хүрлээ. ХЗХ-дын мөрдөж буй зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр энэхүү үзүүлэлт 5 хувиас бага байх ёстой.


### ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН АНГИЛАЛ

- Чанаргүй зээлийн ангилал дахь хэвийн бус зээлийн эзлэх хувь өнгөрсөн оноос 1.7 пунктээр өсөж 26.4 хувь болжээ.
- Эргэлзээтэй зээлийн хувьд өнгөрсөн оноос 2.3 пунктээр өсөж 21.7 хувьд хүрсэн бол муу зээлийн нийт чанаргүй зээлд эзлэх жин 51.9 хувь байна.




**ХЗХ–ДЫН ХӨРВӨХ ЧАДВАР:**

- ХЗХ–дын мөнгөн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа тайлант жилд 14.9 хувьтай байна.
- Богино хугацаат хөрөнгө оруулалт болон нийт зээлийн нийлбэрийг нийт хөрөнгөд харьцуулсан үзүүлэлт 78.8 хувьтай байна.



- Зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь
- Зээлийн эрсдэлийн сангийн нийт хөрөнгөд эзлэх хувь



**ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САН**

- Тайлант онд ХЗХ–дын зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь 2.5 хувь; харин нийт хөрөнгөд эзлэх хувь 2.0 хувь байна.

Харьцаа	Зохистой хувь	Тайлант улиралд
Бусдаас авсан зээл/Нийт зээл	<20%	2.7%
Нийт хадгаламж/Нийт хөрөнгө	20%–80%	70.0%
Цэвэр зээл/Нийт хөрөнгө	60%–85%	76.6%
Хоршоологчдын өмч/Нийт хөрөнгө	>5%	12.6%
Нөөцийн сан/Хоршоологчдын өмч	>10%	32.3%
Хадгаламж хамгааллын сан/Хоршоологчдын өмч	>5%	7.7%
Тогтворжилтын сан/Хоршоологчдын өмч	>5%	7.9%
Үйл ажиллагааны зардал/Нийт хөрөнгө	<15%	5.3%

## БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



### ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Сангийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/156 тоот тушаалаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн журмыг шинэчлэх” ажлын хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл ажиллаж байна. 2022.11.08–ны өдрийн ажлын хэсгийн хуралд оролцож “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны нэгдсэн жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга бэлтгэх аргачлал”–ын шинэчилсэн найруулгын төслийг танилцуулж, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлж батлуулахаар бэлтгэсэн.
- Монголбанкны ерөнхийлөгчийн 2022 оны А–288 дугаар тушаалаар баталсан “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 18.1 дэх хэсэгт заасан харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг тогтооходой холбогдсон үндэслэл бүхий суурь судалгаа хийх, санал дэвшүүлэх” ажлын хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл ажиллаж, төлөвлөгөөний дагуу банкнаас бусад санхүүгийн байгууллага дахь харилцах дансны хүүгийн нөлөөллийн талаар танилцуулга бэлтгэн 2022.11.25–ны өдөр ажлын хэсгийн ахлагчид хүргүүлсэн.
- Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын 2022 оны А/61 дүгээр тушаалаар Хадгаламж, зээлийн хоршооны мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Ажлын хэсэг 2022.12.01–ний өдөр хуралдаж мэдээлэл солилцсон бөгөөд холбогдох судалгааг хийхээр шийдвэрлэсний дагуу 2022.12.22–ны өдрөөс эхлэн ХЗХ–доос гишүүдийн хадгаламжийн судалгааг авсан.
- “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”–ын төслийг боловсруулж, санал авахаар МХЗХҮХ–нд хүргүүлсэн ба олон нийтээс санал авахаар 2022.12.08–ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсанд байршуулсан. 2022 онд тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулсан 49 ХЗХ–ны санхүүгийн болон удирдлагын чанарын үзүүлэлтэд үндэслэн зайны үнэлгээний аргачлалыг туршиж эхлээд байна.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 687 дугаар тогтоолоор “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”–ыг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн шинэчлэн баталсан. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 723 дугаар тогтоолоор нэр бүхий 54 ХЗХ–ны, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022 оны 543 дугаар тушаалаар нэр бүхий 9 ХЗХ–ны санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг тус тус шийдвэрлэсэн.
- Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022 оны 498 дугаар тушаалаар холбогдох дүрэм, журам, заавар зэргийг боловсруулах, судалгаа шинжилгээ хийх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд 3 дэд ажлын хэсэгт хуваагдан ажиллаж байна.



#### ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Жижиг дунд үйлдвэрлэлийн газрын хамтарсан БЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох сургалтын төлөвлөгөөний дагуу 2022.10.13-ны өдөр Чингэлтэй дүүрэг, 2022.10.19-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн БЖДҮ эрхлэгчдэд зориулсан сургалтыг зохион байгуулж "Банк болон банкнаас бусад санхүүгийн байгууллага" сэдвээр мэдээлэл өгсөн.
- АХБ-ны "Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө Зүүн Азийн жендерийн тэгш байдлыг эрчимжүүлэх төсөл"-ийн дэд хэсэг болох "Ногоон санхүүгийн хүртээмж, жендерийн тэгш байдлыг дэмжих төсөл"-ийг Монгол Улсад хэрэгжүүлэх хамтрагч байгууллага Байгаль орчин, аялал жуулчлалын яам, ТоС-ын холбооноос хамтран 2022.11.29-ний өдөр зохион байгуулсан төслийн эхлэлтийн хэлэлцүүлэгт оролцож Санхүүгийн зохицуулах хорооны хариуцан гүйцэтгэх ажлын талаар мэдээлэл өгсөн.



#### ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- АХБ-ны "Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө Зүүн Азийн жендерийн тэгш байдлыг эрчимжүүлэх төсөл"-ийн дэд хэсэг болох "Ногоон санхүүгийн хүртээмж, жендерийн тэгш байдлыг дэмжих төсөл"-ийг ХЗХ-ны зах зээлд 2022-2024 онд хэрэгжүүлэхээр дотоодын зөвлөх ажиллаж байна. Төслийн хүрээнд ХЗХ-дын гишүүн эмэгтэй удирдлага бүхий БЖДҮ эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох, ногоон санхүүжилтийн хэрэгцээг тодорхойлох суурь судалгааг хийх бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа



# ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Нийт хөрөнгө

**258.6**  
тэрбум төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Нэг батлан даалтын  
дундаж хэмжээ

**343.3**  
сая төгрөг



Хүртээмжтэй байдал

Ирүүлсэн  
хүсэлтийн тоо **75**

Зөвшөөрөгдсөн  
хүсэлтийн тоо **42**



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Нийт орлого

**12.2** тэрбум төгрөг

Нийт ашиг

**8.6** тэрбум төгрөг

Тогтвортой байдал




Чанаргүй батлан  
даалтын эзлэх хувь

**15.0%**


## САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ



2022 оны байдлаар Сангийн нийт хөрөнгийн хэмжээ 258.6 тэрбум төгрөг хүрч өмнөх онтой харьцуулахад 1.4 хувиар буюу 3.5 тэрбум төгрөгөөр өслөө.




- Сангийн батлан даалтын үлдэгдэл 2022 оны байдлаар 78.1 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 8.5 хувиар буюу 7.3 тэрбум төгрөгөөр буурчээ.
- Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл өмнөх оноос 8.1 хувиар буюу 13.6 тэрбум төгрөгөөр буурч 153.5 тэрбум төгрөг болжээ.




- 2022 онд нийт 13.7 тэрбум төгрөгийн 40 батлан даалтыг шинээр гаргасан нь өмнөх онтой харьцуулахад батлан даалтын тоо 6 дахин, батлан даалтын дүн 2.5 дахин буурсан үзүүлэлттэй байна.




## ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ




### НИЙТ БАТЛАН ДААЛТЫН ХЭМЖЭЭ





#### НЭГ БАТЛАН ДААЛТЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ


- Нэг батлан даалтын дундаж хэмжээний хувьд Улаанбаатар хотод 359.5 сая төгрөг, хөдөө орон нутагт 251.7 сая төгрөг, улсын хэмжээнд 343.3 сая төгрөг байна.
- Бүс нутгуудын хувьд Хангайн бүсэд олгосон 1 батлан даалтын хэмжээ хамгийн их буюу 510.0 сая төгрөг байна.



## БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

	Батлан даалт гаргуулахаар ирүүлсэн хүсэлтийн тоо	Зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо	Эзлэх хувь
2019	193	113	58.5%
2020	128	72	56.3%
2021	334	244	73.0%
2022	75	42	56.0%


Батлан даалт гаргуулах нийт 75 хүсэлт ирснээс 42 хүсэлт нь зөвшөөрөгдсөн байна. Үүнээс 40 хүсэлтийн батлан даалтыг олгожээ. Ирүүлсэн хүсэлтийн тоо нь өмнөх оноос 4.5 дахин, зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо 5.8 дахин буурсан байна. Хүсэлтийн зөвшөөрлийн хувь 56.0 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 17.0 пунктээр буурсан байна.



Олгосон батлан даалтын 39.3 хувийг үйлдвэрлэлийн салбарт, 31.4 хувийг үйлчилгээний салбарт, 22.4 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 4.7 хувийг барилгын салбарт, 2.2 хувийг хөдөө аж ахуйн салбарт тус тус гаргасан байна. Өмнөх онтой харьцуулахад бөөний болон жижиглэн худалдааны салбарт гаргасан батлан даалтын эзлэх хувь 36.1 пунктээр буурсан бол үйлчилгээний салбарт 21.0 пунктээр, үйлдвэрлэлийн салбарт 20.0 пунктээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

- 2022 онд гаргасан батлан даалтын дундаж хугацаа 84.8 сар буюу 7.1 жил байна.
- Энэ үзүүлэлт нь өмнөх оноос 41 сар буюу 3.4 жилээр уртассан үзүүлэлт юм.
- Тайлант онд урт хугацаатай цөөн тооны батлан даалтыг олгосон байна.

**84.8**  
САР



2022 онд Сангаас гаргасан батлан даалтын 51.6 хувийг Капитрон банк, 28.0 хувийг Хаан банк, 10.1 хувийг Голомт банк, 5.6 хувийг Төрийн банк, 0.9 хувийг Худалдаа хөгжлийн банк, 3.6 хувийг Ариг банк, 0.2 хувийг Транскапитал ББСБ-ын зээлд гаргасан батлан даалт бүрдүүлж байна.

## АШИГТ АЖИЛЛАГАА




## Орлогын бүтэц



## Зарлагын бүтэц



## Нийт хөрөнгийн өгөөж





Сангийн нийт хөрөнгийн өгөөж 3.3 хувь байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.7 пунктээр буурсан байна.

## ТОГТВОРТОЙ БАЙДАЛ


2022 оны байдлаар чанаргүй батлан даалтын үлдэгдэл 11.7 тэрбум төгрөгт хүрлээ.

Чанаргүй батлан даалтын үлдэгдэл /тэрбум төгрөг/



Батлан даалтын нийт үлдэгдэлд эзлэх чанаргүй батлан даалтын хувь 15.0 болж өмнөх оноос 1.8 пунктээр өслөө.

- Чанаргүй батлан даалтын үлдэгдлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 44.2 хувь нь үйлдвэрлэлийн салбарт, 30.6 хувь нь үйлчилгээний салбарт, 4.8 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 20.4 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон батлан даалууд бүрдүүлж байна.
- Өмнөх онтой харьцуулахад үйлдвэрлэлийн салбарын чанаргүй батлан даалтын эзлэх хувь 11.6 пунктээр буурсан бол үйлчилгээний салбарын чанаргүй батлан даалтын эзлэх хувь 5.2 пунктээр өссөн байна.





# ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАР

Зохицуулалттай этгээд

**305**



Салбарын төлөв

ҮХХ зуучлалын  
хэлцэл

**16,753**



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Хүртээмжтэй байдал



**99.0%**

Улаанбаатар хотод үйл  
ажиллагаа эрхлэгчид

Бодлого зохицуулалт





## САЛБАРЫН ТӨЛӨВ



Санхүүгийн  
зохицуулах хорооны  
тусгай зөвшөөрөлтэй  
**305**

## ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН ТОО

2022 онд тусгай зөвшөөрөлтэй 305 үл хөдлөх эд хөрөнгө зуучлал /ҮХЭХЗ/-ын компани үйл ажиллагаа явуулсан ба өмнөх оноос 57-оор өссөн байна. Тайлант онд 3 компанийн үйл ажиллагааг хүчингүй болгож, 60 компани шинээр тусгай зөвшөөрөл авчээ.



Тайлант онд ҮХЭХЗ-ын компаниуд 319 брокер, 1495 агенттай ажилласан байна.

Нэг ҮХЭХЗ-ын компани дунджаар 1 брокер, 5 агенттай байна.

Хамгийн олон агенттай ҮХЭХЗ-ын компанийн агентын тоо 90 байна.

## НИЙТ ХӨРӨНГӨ

ҮХЭХЗ-ын компаниудын нийт хөрөнгө 197.1 тэрбум төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 101.1 тэрбум төгрөгөөр буюу 2 дахин өссөн байна.

Нийт хөрөнгийн 175.8 тэрбум төгрөг буюу 89.2 хувийг эргэлтийн хөрөнгө, үлдсэн 21.3 тэрбум төгрөг буюу 10.8 хувийг эргэлтийн бус хөрөнгө, эх үүсвэрийн 174.7 тэрбум төгрөг буюу 88.6 хувийг өр төлбөр, 22.4 тэрбум төгрөг буюу 11.4 хувийг эздийн өмч тус тус эзэлж байна.

Хөрөнгө, эх үүсвэрийн  
ангилал

Мөнгөн дүн  
/тэрбум төгрөг/

Хөрөнгө болон эх үүсвэрт  
эзлэх хувь

Эргэлтийн хөрөнгө

175.8

89.2%

Эргэлтийн бус хөрөнгө

21.3

10.8%

Өр төлбөр

174.7

88.6%

Эздийн өмч


22.4

11.4%

### ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

ҮХЭХЗ–ын компаниудын нийт хөрөнгийн дүнгээр зах зээлд эзлэх хувийг тооцоход зах зээлийн 83.8 хувийг 10 компани, харин үлдсэн 16.2 хувийг 295 компани бүрдүүлж байна.

Нийт хөрөнгийн дүнгээр зах зээлийн 0.25 хүртэлх хувийг эзэлж буй 279 ҮХЭХЗ–ын компани, 0.26–аас 0.5 хувийг эзэлж буй 9 компани, 0.51–ээс 1.0 хүртэлх хувийг 6 компани, 1.1–ээс 5 хувь хүртэл 8 компани, 10–аас дээш хувийг 3 компани тус тус бүрдүүлж байна.



### ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗ–ын байгууллагуудын 465 хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 6.2 тэрбум төгрөг болсон нь өмнөх оноос 3 дахин буурсан байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 15.0 тэрбум төгрөгөөр буурахад нэг компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болсон нь нөлөөлсөн.


ҮХЭХЗ–ын компаниудын хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хувьд 95.1 хувийг иргэд, 3.7 хувийг хуулийн этгээд, үлдсэн 1.2 хувийг иргэн, хуулийн этгээд хамтран эзэмшиж байна.



### ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ, ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

2022 онд 272 ҮХЭХЗ-ын компани 8,983 хэлцлээр, 1,971.5 мянган м.кв талбай, 1,705.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий 4 төрлийн үл хөдлөх хөрөнгийг зуучлан худалдан, шилжүүлжээ.


Үл хөдлөх хөрөнгийг зуучлан худалдан, борлуулах үйлчилгээний дүн өмнөх оноос 2 дахин буюу 852.7 тэрбум төгрөгөөр өслөө.



### ТҮРЭЭСЛЭХ, ТҮРЭЭСЛҮҮЛЭХ, ХӨЛСЛӨХ, ХӨЛСЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ


Тайлант хугацаанд 7700 хэлцлээр 840.2 мянган м.кв талбай, 444.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан хөлслүүлж, түрээслүүлжээ.

Үл хөдлөх хөрөнгийг зуучлан түрээслэх, түрээслүүлэх үйлчилгээ өнгөрсөн оноос 420.5 тэрбум төгрөгөөр буюу 18.8 дахин өссөн байна.



## ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

### ҮХЭХЗ–ЫН БАЙГУУЛЛАГУУДЫН БАЙРШИЛ:



Нийт тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗ–ын компаниудын 28.5 хувь нь Сүхбаатар, 25.9 хувь нь Хан–Уул, 18.4 хувь нь Баянзүрх, 12.4 хувь нь Баянгол, 11.8 хувь нь Чингэлтэй, 2.0 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт тус тус үйл ажиллагаа эрхэлж байгаа бол хөдөө, орон нутагт 3 ҮХЭХЗ–ын компани буюу 1.0 хувь нь үйл ажиллагаа эрхэлж байна.

## БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /ДАВХАРДСАН ТООГООР/



### ШИГТГЭЭ

www.forbes.com цахим хуудаст үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэ 2022 онд өндөр инфляц, геополитикийн асуудал, үл хөдлөх хөрөнгийн нийлүүлэлтийн хомсдолоос улбаатай өссөн бол 2023 онд уг байдал үргэлжлэх хандлагатай байна.

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН БОРЛУУЛАХ ЗУУЧЛАЛ /ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН АНГИЛЛААР/



Арилжааны ангиллын мэдээнд үндэслэн худалдсан үл хөдлөх хөрөнгийн хэлцлийн 85.7 хувийг орон сууц, 9.8 хувийг арилжааны, 3.8 хувийг газар, 0.7 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай үл хөдлөх хөрөнгө эзэлж байна.




ҮХЭХЗ-ын компаниудын ирүүлсэн мэдээгээр худалдсан үл хөдлөх хөрөнгийн талбайн 66.6 хувийг газар, 30.2 хувийг орон сууц, 2.9 хувийг арилжааны, 0.3 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай үл хөдлөх хөрөнгө эзэлж байна.




ҮХЭХЗ-ын компаниудын ирүүлсэн мэдээгээр худалдсан үл хөдлөх хөрөнгийн арилжсан дүнгийн 89.2 хувийг орон сууц, 7 хувийг арилжааны, тус бүр 1.9 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай үл хөдлөх хөрөнгө болон газар эзэлж байна.

Худалдан, худалдан авахад зуучилсан үл хөдлөх хөрөнгө талбайн хэмжээгээр 50-аас доош м.кв бүхий үл хөдлөх хөрөнгө 40.9 хувийг, 51-ээс 100 м.кв хүртэлх 45.2 хувийг, 101-ээс 400 м.кв хүртэлх 9.0 хувийг, 401 м.кв-аас дээших талбайтай нь 4.9 хувийг тус тус эзэлж байна.

Шимтгэлийн хувь / Борлуулсан хэлцлийн тоогоор/




Талбайн хэмжээ /Борлуулсан хэлцлийн тоогоор/\*




### ТҮРЭЭСЛЭХ, ТҮРЭЭСЛҮҮЛЭХ, ХӨЛСЛӨХ, ХӨЛСЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Үл хөдлөх хөрөнгийг зуучлан хөлслүүлж, түрээслүүлсэн хэлцлийн 79.9 хувийг орон сууцны, 19.6 хувийг арилжааны болон 0.3 хувийг үйлдвэрийн зориулалттай үл хөдлөх хөрөнгө, 0.2 хувийг газрын түрээсийн зуучлал эзэлж байна.




Зуучилсан үл хөдлөх хөрөнгийн түрээсийг байршлаар нь харвал Хан-Уул дүүрэгт хамгийн өндөр буюу 32 хувь, Баянзүрх дүүрэгт 27.9 хувь, Сүхбаатар дүүрэгт 17.2 хувь, Баянгол дүүрэгт 13.1 хувь, Чингэлтэй дүүрэгт 5.2 хувь, Сонгинохайрхан дүүрэгт 3.6 хувь, хөдөө, орон нутагт 0.9 хувь, Налайх дүүрэгт 0.1 хувь тус тус хийгджээ.

Шимтгэлийн хувь  
/Түрээсэлсэн хэлцлийн тоогоор/




Талбайн хэмжээ  
/Түрээсэлсэн хэлцлийн тоогоор/



Түрээсийн төлбөрийн нийт дүнд эзлэх хувиар

\* Шимтгэлийн хувь болон талбайн хэмжээний хэлцлийн тооны зөрүү нь 0 дүнтэй тоон мэдээллийг хасаж тооцсон болно.

## АШИГТ АЖИЛЛАГАА



	<1%	<5%	<10%	>10%
Нийт хөрөнгийн өгөөж ROA 2022	81.6%*	6.9%	3.3%	8.2%
Өөрийн хөрөнгийн өгөөж ROE	64.2%	1.3%	2%	32.5%

ROE болон ROA-ийн харгалзах интервал дахь ҮХЭХЗ-ын компанийн тоо /хувиар/ (\*)


Жишээ нь: Нийт ҮХЭХЗ-ын компаниудын 81.6 хувь нь 1 хувиас доош хөрөнгийн өгөөжтэй ажиллаж байна.

## ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

### БОГИНО ХУГАЦААНЫ ХӨРВӨХ ЧАДВАР

2022 онд үйл ажиллагаа явуулсан 305 ҮХЭХЗ-ын компаниас 50 нь богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

### ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ БА ЭРГЭЛТИЙН ӨР ТӨЛБӨРИЙН ХАРЬЦАА



Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлтэй 50 ҮХЭХЗ-ын компанийн эргэлтийн хөрөнгийн харьцааг тооцоход 2-оос дээш гарсан 21, 1-ээс 2-ын хооронд гарсан 9, 1-ээс бага гарсан 20 ҮХЭХЗ-ын компани байна.

### УРТ ХУГАЦААНЫ ХӨРВӨХ ЧАДВАР

Урт хугацаат хөрвөх чадварын хувьд 175 ҮХЭХЗ-ын компани урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Тэдгээрийн өр төлбөр, хөрөнгийн харьцааг тооцож үзэхэд өр төлбөр нь нийт хөрөнгийн 50-аас бага хувийг эзэлж буй 48, 50-аас 100 хувийн хооронд эзэлж буй 51, 100-аас их 76 ҮХЭХЗ-ын компани байна.

Нийт хөрөнгө ба эздийн өмчийн дундажаар тооцсон санхүүгийн хөшүүргийн харьцаа тайлант онд 78 ҮХЭХЗ-ын компанийн хуримтлагдсан алдагдал эздийн өмчийн хэмжээг давсан байна.

96 ҮХЭХЗ-ын компани 100 хувь өөрийн хөрөнгөөрөө ажиллаж байна.

76 ҮХЭХЗ-ын компанийн хөшүүргийн харьцаа 2 байна.

55 ҮХЭХЗ-ын компанийн хөшүүргийн харьцаа 2-оос дээш байна.



## БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



### ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Зөвшөөрлийн тухай хууль батлагдсаны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам” – ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 363 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам” –д нэмэлт өөрчлөлт оруулан Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 686 дугаар тогтоолоор баталсан.
- Дэлхийн банкны санхүүжилтээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх дотоодын зөвлөхтэй хамтран Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагааны зохицуулалтын тухай хуулийн төслийг боловсруулсан.
- Монгол Улсын үл хөдлөх хөрөнгийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэх, орон сууцны үнийн индексийг тооцож, иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилтын хүрээнд Барилга хот байгуулалтын яамны хэрэгжүүлж буй “Орон сууцны мэдээллийн нэгдсэн портал” системд ҮХЭХЗ–ын компанийн зуучлан борлуулсан орон сууцны мэдээллийг гаргах цэсийг хөгжүүлэх ажлыг БХБЯ–ны технологийн хэлтэс, Геодези зураг зүйн газрын хот байгуулалын кадастрын хэлтэс, “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УҮГ–тай хамтран гүйцэтгэсэн.
- “Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын бизнес эрхлэгчдийн нэгдсэн дээвэр холбоо” ГҮТББ–тай 2022.12.26–ны өдрийн 03 тоот “Харилцан ойлголцлын санамж бичиг” –ийг байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлсэн.



### ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагааны зохицуулалтын тухай хуулийн төслийг Ажлын албаны даргад танилцуулж, Хууль, эрх зүйн хэлтэстэй уулзалт зохион байгуулан харилцан санал солилцсон.
- БХБЯ–ны технологийн хэлтэс, Геодези зураг зүйн газрын хот байгуулалын кадастрын хэлтэс, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв, Хяналт шалгалт зохицуулалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх алба, Мэдээллийн технологийн хэлтэс, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газартай 2022.03.02–ны өдөр уулзалт зохион байгуулж, орон сууцны тухай хуульд заасан орон сууцны мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, сүлжээ байгуулах чиглэлд хамтран ажиллахаар санал солилцов.
- “Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын бизнес эрхлэгчдийн нэгдсэн дээвэр холбоо” ГҮТББ, “ANR–Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын нэгдсэн холбоо” ГҮТББ, Үндэсний үл хөдлөх хөрөнгийн хөгжлийн нийгэмлэг болон Санхүүгийн боловсрол, сургалтын албатай хамтарсан уулзалтыг 2022.09.02–ны өдөр зохион байгуулж, үл хөдлөх хөрөнгө зуучлагчдыг мэргэшүүлэх, мэргэжлийн индексийг бий болгох, мөн мэргэжлийн эрх олгох сургалтыг сайжруулах хүрээнд санал солилцлоо.
- Үндэсний үл хөдлөх хөрөнгийн хөгжлийн нийгэмлэг болон Санхүүгийн боловсрол, сургалтын албатай хамтарсан уулзалтыг 2022.09.07–ны өдөр зохион байгуулж, үл хөдлөх хөрөнгийн салбарын нэр томъёог бий болгох, үл хөдлөх хөрөнгө зуучлагчдыг мэргэшүүлэх сургалтыг сайжруулах боломжийн талаар санал солилцсон.



# ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАР

Арилжаа эрхлэгчдийн тоо

**47**

Хуулийн этгээд



Салбарын төлөв

**465**

Иргэн

Худалдан авсан үнэт  
металл

**700.1**

тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Хүртээмжтэй байдал



81.4%

Улаанбаатар хотод үйл  
ажиллагаа явуулж буй  
арилжаа эрхлэгч

Бодлого зохицуулалт




## САЛБАРЫН ТӨЛӨВ

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТОО:

2022 оны байдлаар 47 хуулийн этгээд, 465 иргэн тусгай зөвшөөрөлтэйгөөр үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааг эрхэлж байна.

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ  
ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН  
АРИЛЖАА ЭРХЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД

47




70

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ  
ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН  
АРИЛЖАА ЭРХЛЭГЧ

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА  
ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ  
ИРГЭД

140



255

ҮНЭТ МЕТАЛЛ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУГААР  
ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ  
ИРГЭД

### ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Тайлант онд тусгай зөвшөөрөлтэй 47 хуулийн этгээдийн 75 хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 9.4 тэрбум төгрөг байна.


Тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгчдийн 81.4 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 18.6 хувь нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

Улаанбаатар хотод

81.4%

## ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

### ҮНЭТ МЕТАЛЛ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ /БАЙРШЛААР/



Тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхэлж буйг байршлаар нь авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн 56.4 хувь нь хөдөө, орон нутагт, 43.6 хувь нь Улаанбаатар хотод;

Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн 96.9 хувь нь Улаанбаатар хотод, 3.1 хувь нь хөдөө орон нутагт;

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн 90 хувь нь Улаанбаатар хотод, 10 хувь нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

**ӨМНӨГОВЬ 2**  
**ДАРХАН-УУЛ 1**  
**ГОВЬ-АЛТАЙ 2**  
**ХЭНТИЙ 1**  
**УВС 1**

Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

**ХОВД 2**  
**ДАРХАН-УУЛ 5**  
**БАЯНХОНГОР 1**

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч

**БАЯНХОНГОР 15**  
**СЭЛЭНГЭ 21**  
**ТӨВ 14**  
**ДАРХАН-УУЛ 11**  
**ГОВЬ-АЛТАЙ 3**  
**ӨМНӨГОВЬ 6**  
**УВС 2**  
**ДОРНОГОВЬ 1**  
**ӨВӨРХАНГАЙ 1**  
**ХОВД 4**  
**ДОРНОД 1**

## БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

### ХУДАЛДАЖ, ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ МЕТАЛЛЫН ДҮН

Тайлант онд 8.5 тонн үнэт металлыг 700.1 тэрбум төгрөгөөр худалдан авч, 8.3 тонн үнэт металлыг 670.8 тэрбум төгрөгөөр борлуулсан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулбал худалдан авсан үнэт металлын хэмжээ 116.5 тэрбум төгрөгөөр буюу 20 хувиар өссөн бол худалдсан үнэт металлын хэмжээ 23.4 тэрбум төгрөгөөр буюу 3.4 хувиар буурсан байна.

### ҮНЭТ МЕТАЛЛ ЭРХЛЭГЧИД БОЛОН ИРГЭД, АЖ АХУЙ НЭГЖ ХООРОНДЫН АРИЛЖАА



### ХУДАЛДАЖ, ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ДҮН



**ХУДАЛДАЖ  
АВСАН  
ҮНИЙН ДҮН**

Үнэт эдлэлийн 14.7 тэрбум төгрөгийн худалдан борлуулалт хийгдсэн байна.

## АШИГТ АЖИЛЛАГАА

### НИЙТ ХӨРӨНГӨ БА ЦЭВЭР АШИГ

2022 онд 47 үнэт металл, үнэт эдлэл, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн нийт хөрөнгө 58.0 тэрбум төгрөг ба өмнөх оноос 41.4 хувиар буюу 24.0 тэрбум төгрөгөөр өссөн байна. Цэвэр ашиг 14.1 тэрбум төгрөг ба өмнөх оноос 5 дахин өссөн байна.

### Санхүүгийн байдлын тайлангийн голлох үзүүлэлтүүд:

Эргэлтийн хөрөнгө

**44.0**

тэрбум төгрөг

Эргэлтийн бус хөрөнгө

**14.0**

тэрбум төгрөг



Өр төлбөр

**42.0**

тэрбум төгрөг

Эздийн өмч

**16.0**

тэрбум төгрөг

### Орлого, үр дүнгийн тайлангийн голлох үзүүлэлтүүд:

НИЙТ ОРЛОГО  
**72.3 ТЭРБУМ  
ТӨГРӨГ**

НИЙТ ЗАРДАЛ  
**58.2 ТЭРБУМ  
ТӨГРӨГ**

ЦЭВЭР АШИГ  
**14.1 ТЭРБУМ  
ТӨГРӨГ**

Нийт ахиуц ашиг  
**40.7%**

Цэвэр ахиуц ашиг  
**19.7%**

## БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



### ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Зөвшөөрлийн тухай хууль батлагдсаны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 150 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам” болон 2020 оны 182 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.
- “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын шинэчилсэн найруулгын төсөлд бичил уурхай эрхлэгчид нь арилжааны банк болон Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй иргэдэд олборлосон алтыг борлуулах зохицуулалтыг нэмж тусгах зарчмын шинжтэй саналыг хүргүүлснээр Монгол Улсын Засгийн газрын 2022.08.03-ны өдрийн 296 дугаар тогтоолоор тус журам батлагдсан.
- Монгол Улсын хэмжээнд үнэт эдлэлийн борлуулалтын нэгтгэл тайланг гаргах, зайны хяналтыг хялбаршуулах, санхүүгийн анхан шатны баримтаар баталгаажсан тоо мэдээг гаргах, үнэт эдлэлийн борлуулалтын их өгөгдлийн санг бүрдүүлэх ажлын хүрээнд “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УҮГ-тай хамтран “Цахим төлбөрийн систем”-ийн аналитик системд хандах ажлыг эхлүүлсэн.
- Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хүрээнд салбарын зохицуулалтыг боловсронгуй болгох “Зөвлөмж”-ийг холбогдох нэр бүхий 16 төрийн байгууллагуудаас ирүүлсэн саналыг тусган боловсрууллаа.



### ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдийн бизнес, борлуулалтын үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Mongolian jewellery & metal expo-2022” үзэсгэлэнг “Мишээл экспо” олон улсын худалдааны танхимд “Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн нэгдсэн холбоо” ГҮТББ-тай хамтран зохион байгуулсан. Мөн дээрх төрлийн тусгай зөвшөөрлийн талаарх ойлголтыг иргэд, олон нийтэд хүргэх зорилгоор Монгол Улсын ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагддаг “МОНГОЛ УРАН ДАРХАН 2022” үзэсгэлэн, “Монголын уламжлалт гар урлал” арга хэмжээнд тус тус оролцсон.
- Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, Азийн сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан уул уурхайн салбарт бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй нэгжүүдийн мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор “Хууль бус олборлолттой тэмцэх чадавхыг бэхжүүлэх” төслийг хэлэлцүүлэгт оролцож, санал солилцсон.
- Бичил уурхай эрхлэгчдийг албажуулах, алтны гарал үүслийг тодорхойлох, нийлүүлэлтийн сүлжээг ил тод болгох ажлын хүрээнд “The PlanetGold” төслийн Монгол Улс дахь суурин төлөөлөгчидтэй 2022.09.13-ны өдөр уулзаж санал солилцсон. Тус уулзалтаар хэлэлцсэн ажлыг эрчимжүүлж 2022.10.13-14-ний өдрүүдэд “Алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээтэй танилцах” үзлэг, хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулав.
- Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд шаардлагатай мэдээ, мэдээллийг хүртээмжтэй байдлаар хүргэх зорилгоор ҮМҮЧЭТХЭАЭ-ийн эрх олгох цахим сургалтын системийг бий болголоо.





# СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН



Хүсэлтийн тоо


15



Салбарын төлөв

Сэндбоксад  
туршигдаж буй  
бүтээгдэхүүнүүд

4



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

## ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫ ТӨЛӨВ

### Сэндбоксын орчинд ирүүлсэн хүсэлт, бүтээгдэхүүн үйлчилгээний төрлөөр:



### Сэндбоксад туршигдаж буй бүтээгдэхүүнүүд

2022 оны 4 дүгээр улиралд дараах нэр бүхий 3 бүтээгдэхүүн, үйлчилгээг сэндбокс зохицуулалтын орчинд 1 жилийн хугацаатайгаар нэмж оруулан, 1 бүтээгдэхүүнийг гаргаж нийт 4 бүтээгдэхүүн, үйлчилгээ туршиж байна.



Монимаркет вэб системээр дамжуулан репо хэлцлийн хүсэлт хүлээн авах, хэлцлийн дагуу худалдах, худалдан авах үйлчилгээ. Тус платформоор 2022 онд нийт 305 удаагийн хэлцлээр 40,4 тэрбум төгрөгийн репо арилжаа хийгдсэн байна.



Зээл.мн P2P үйлчилгээ нь Монгол Улсын санхүүгийн зах зээлд шинээр нэвтэрч буй үйлчилгээ бөгөөд хиймэл оюун ухаан, блокчэйн технологийг ашиглан зээлийн онооны үнэлгээ, бүртгэл хийн хөрөнгө оруулагч, зээлдэгч хоёрыг шууд холбодог давуу талтай.



Худалдагч

Платформ

Худалдан авагч

64.06 тэрбум төгрөгийн арилжаа



Лайка үйлчилгээ нь технологид суурилсан даатгалын үйлчилгээ бөгөөд хэрэглэгч өөрийн хэрэгцээ шаардлага, эрсдэлд нийцсэн даатгалын бүтээгдэхүүнийг ямар нэгэн зуучлагчгүйгээр өөрөө сонгон хэрэглэх, мөн эрсдэлд суурилсан газрын зураглалыг хөгжүүлж, даатгалын эрсдэлийг үнэлэх зэрэг олон төрлийн давуу талыг хэрэглэгчдэд санал болгож буй.

### Сэндбоксоос гарсан үйлчилгээ



Монпэй дижитал бонд нь 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд сэндбоксын орчинд туршигдаж 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Сэндбоксын зөвлөлийн 04 дүгээр зөвлөмжөөр сэндбокс зохицуулалтын орчноос гаргасан.



Финбэрри үйлчилгээ нь зээл, урамшуулал, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээ бөгөөд жижиг, дунд, бизнес эрхлэгчид, аж ахуй нэгжүүдэд төслийн санхүүжилтийн хэрэгцээгээ түргэн шуурхай шийдэх боломжийг санал болгож байна.



# ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ

Бүртгэгдсэн платформ

11



Салбарын төлөв

Анхдагч зах зээл  
дээрээс татан  
төвлөрүүлсэн  
хөрөнгийн хэмжээ



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

970.0 тэрбум төгрөг

Хүртээмжтэй байдал



Өдрийн дундаж арилжаа  
**250.0** сая төгрөг

Бодлого зохицуулалт



## САЛБАРЫН ТӨЛӨВ

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар дотоод виртуал хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 326.1 тэрбум төгрөг, харин өдрийн нийт дундаж арилжаа 250.0 сая төгрөг байна.




9

Нийт бүртгэсэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч

Санхүүгийн зохицуулах хороонд 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар 11 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч /ВХҮҮ/ бүртүүлсэн нь өмнөх улиралтай харьцуулахад 2-оор буюу 22.2 хувиар өссөн үзүүлэлт юм.

Мөн дотоодын виртуал хөрөнгө /ВХ/ өмнөх улирлаас 2.1 дахин нэмэгдэж 40 боллоо.



210  
койн/токен

170 гадаад  
40 дотоод



Санхүүгийн зохицуулах хороонд 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар 11 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч /ВХҮҮ/ бүртүүлсэн нь өмнөх улиралтай харьцуулахад 2-оор буюу 22.2 хувиар өссөн үзүүлэлт юм.

Мөн дотоодын виртуал хөрөнгө /ВХ/ өмнөх улирлаас 2.1 дахин нэмэгдэж 40 боллоо.




Анхдагч болон хоёрдогч зах зээл дээр гарсан



Анхдагч зах зээл дээрээс нийт 970 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн байна.

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар ВХҮҮ-дийн харилцагчдын тоо давхардсан тоогоор 837,341 байна. Үүнээс 47.0 хувь нь бүртгэлээ баталгаажуулсан бол 13.4 хувь нь арилжаанд идэвхтэй оролцогчид болно.



Идэвхитэй арилжаа хийж буй харилцагч

Баталгаажуулалт хийсэн

Нийт харилцагч

## БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



### ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хороод Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох 10 харилцааг зохицуулах дараах 8 журмыг баталж хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

- o Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам
- o Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам
- o Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээр хяналт шалгалт хийх журам
- o Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох, түр зогсоох, бүртгэлээс хасах журам
- o Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам
- o Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох журам
- o Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам
- o Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоонд тавих шаардлагыг тогтоох журам



### ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- o Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдаж, 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооноос Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох 10 харилцааг зохицуулах 8 журмын төсөл боловсруулах, хууль сурталчлах зорилгоор 13 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.
- o Санхүүгийн зохицуулах хороо Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх компанийн аудиторыг бэлдэх сургалтыг 2022 оны 10 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд сарын хугацаатай зохион байгууллаа.



### ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- o Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоонд тавих шаардлагыг тогтоох журмын хүрээнд бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн 51-ээс доошгүй хувийг гишүүнээр элсүүлсэн байх шаардлагын дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй 11 компаниас 10 нь Монголын биржүүдийн нэгдсэн холбоонд гишүүнчлэлээр элссэн тул Санхүүгийн зохицуулах хороо ээлжит хуралдаанаар хамтын ажиллагааны санамж бичиг байгуулахаар шийдвэрлэсэн.
- o Санхүүгийн зохицуулах хороо виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарыг хөгжүүлэх, зохицуулалтын зохистой орчин бүрдүүлэх, мэргэжлийн оролцогчдоо чадавхжуулах, мэргэшүүлэх, эрх ашгийг нь хамгаалах зэргээр Монголын биржүүдийн нэгдсэн холбоотой хамтран ажиллахаар 2022.12.28-ны өдөр хамтын ажиллагааны санамж бичиг үзэглэлээ.

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2020	2021	2022
Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/	3,029.7	5,982.90	6,890.4
ЗЗҮ/ДНБ	8.2%	15.3%	14.0%
Хөрвөх чадвар	1.8%	5.1%	2.4%
Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/	53.9	304.9	343.4
Компанийн өрийн хэрэгслийн арилжаа /тэрбум төгрөг/	5.8	1,048.2	134.1
ЗГҮЦ-ны арилжаа /тэрбум төгрөг/	0.6	–	–
Хөрөнгө оруулалтын сан /тэрбум төгрөг/	5.1	56.8	13.6
ТОП-20 индекс	19,285.8	44,411.6	37,565.6
MSE А индекс	9,122.0	15,482.8	14,137.9
MSE В индекс	7,581.1	12,202.6	12,667.4
ХК-ийн тоо	315	314	318
ҮЦК-ийн тоо	53	55	52
ХАА-н биржийн арилжааны дүн /тэрбум төгрөг/	488.7	792.7	1,110.00

## ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2020	2021	2022
Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/	382.1	425.4	474.9
Даатгалын болон давхар даатгалын нийт хураамж /тэрбум төгрөг/	205.1	247.5	304.8
Нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөг/	59.8	68.9	94.2
Нөөц сан /тэрбум төгрөг/	173.5	193.7	216.9
Давхар даатгалын хураамж /тэрбум төгрөг/	66.8	84.4	100.0
Цэвэр ашиг /тэрбум төгрөг/	20.9	25.2	18.5
<b>Мэргэжлийн оролцогчид:</b>			
Ердийн даатгал	14	15	15
Урт хугацааны даатгал	1	1	2
Давхар даатгал	1	1	1
Даатгалын төлөөлөгч	2,473	2,403	2,376
Даатгалын зуучлагч	56	57	63
Хохирол үнэлэгч	25	25	25
Актуарч	32	36	40
Аудитор	145	144	137
Аудитын компани	45	44	40

## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	2020	2021	2022
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,006.9</b>	<b>2,709.9</b>	<b>3,527.0</b>
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>1,927.8</b>	<b>2,616.5</b>	<b>3,415.8</b>
Мөнгөн хөрөнгө	491.5	429.7	490.5
Богино хугацаат хөрөнгө оруулалт	11.9	22.6	29.1
<b>Нийт зээл</b>	<b>1,327.0</b>	<b>2,012.2</b>	<b>2,722.6</b>
Үүнээс: Хэвийн зээл	1,125.7	1,821.9	2,409.1
Хугацаа хэтэрсэн зээл	64.9	50.0	106.5
Чанаргүй зээл	136.4	140.2	207.0
Зээлийн эрсдэлийн сан	104.4	114.7	151.4
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	15.0	13.6	24.2
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>79.1</b>	<b>93.5</b>	<b>111.2</b>
<b>Нийт өр төлбөр</b>	<b>556.2</b>	<b>910.8</b>	<b>1,335.4</b>
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	146.9	246.9	381.1
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	171.2	282.9	396.8
Төслийн зээлийн санхүүжилт	20.8	19.9	30.0
<b>Эзэмшигчдийн өмч</b>	<b>1,450.7</b>	<b>1,799.1</b>	<b>2,191.6</b>
Хоёрдогч өглөг	0.8	70.2	76.0
Хувьцаат капитал	1,017.7	1,114.1	1,275.7
Хуримтлагдсан ашиг	398.1	563.3	774.8
<b>ББСБ-ын тоо</b>	<b>532</b>	<b>534</b>	<b>513</b>
Үүнээс: УБ хот	455	451	420
Хөдөө, орон нутаг	77	83	93
Харилцагчдын тоо	2,844,782	4,820,624	4,633,616
<b>Нийт орлого</b>	<b>408.8</b>	<b>521.3</b>	<b>867.8</b>
Хүүгийн орлого	337.9	421.7	701.9
Хүүгийн бус орлого	62.2	87.0	149.9
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	8.5	12.5	15.8
<b>Нийт зардал</b>	<b>254.0</b>	<b>311.3</b>	<b>554.9</b>
Хүүгийн зардал	42.6	48.0	95.6
Хүүгийн бус зардал	148.0	193.5	335.2
Болзошгүй эрсдэлийн зардал	30.4	37.3	69.1
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	4.3	6.7	8.2
Орлогын албан татварын зардал	28.7	25.8	46.8
<b>Цэвэр ашиг</b>	<b>154.8</b>	<b>210.0</b>	<b>312.9</b>

## ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	2020	2021	2022
<b>Нийт хөрөнгө</b>	<b>256</b>	<b>291.2</b>	<b>267.7</b>
Эргэлтийн хөрөнгө	251.6	280.1	263.6
Мөнгөн хөрөнгө	77.7	61.3	40
Авлага	9.4	9.1	15.8
Эргэлтийн бус хөрөнгө	4.4	11.1	4.1
Үндсэн хөрөнгө /цэврээр/	4.1	3.9	3.9
Биет бус хөрөнгө	0.2	7.2	0.2
Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.0	0.0
<b>Нийт зээл</b>	<b>167.6</b>	<b>213.4</b>	<b>210.2</b>
Хэвийн зээл	154.7	202.1	197.3
Хугацаа хэтэрсэн зээл	5.5	3.9	5.9
Чанаргүй зээл	7.4	7.4	7.0
<b>Өр төлбөр</b>	<b>206.5</b>	<b>227.3</b>	<b>207.9</b>
Хадгаламж	182.2	203.6	187.5
Богино хугацаат зээл	3.0	6.4	2.6
Урт хугацаат өр төлбөр	5.9	2.2	3.1
Бусад богино хугацаат өр төлбөр	15.4	15.1	14.7
<b>Өөрийн хөрөнгө</b>	<b>49.5</b>	<b>63.9</b>	<b>59.8</b>
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	18.5	25.4	25.9
Хоршоологчдын өмч	30.7	38.4	33.7
Хуримтлагдсан орлого /алдагдал/	16.2	21.8	14.7
<b>Нийт орлого</b>	<b>53.1</b>	<b>58.0</b>	<b>58.9</b>
Хүүгийн орлого	50.5	54.2	55.9
Үйл ажиллагааны бусад орлого	1.0	1.3	0.9
Үйл ажиллагааны бус орлого	1.5	2.5	2.1
<b>Нийт зарлага</b>	<b>43.9</b>	<b>47.2</b>	<b>47.3</b>
Хүүгийн зардал	29.3	31.9	30.2
Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	2.1	2.0	1.6
Үйл ажиллагааны зардал	11.5	12.2	14.2
Үйл ажиллагааны бус зардал	0.1	0.3	0.1
<b>Цэвэр орлого</b>	<b>9.2</b>	<b>10.7</b>	<b>11.6</b>
ХЗХ–дын тоо	249	209	196
УБ ХЗХ–дын тоо	148	116	107
Орон нутаг ХЗХ–дын тоо	101	93	89
Гишүүдийн тоо	72,651	75,400	71,657

## ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

/Тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2020	2021	2022
Нийт хөрөнгө	147.1	255.1	258.6
Батлан даалтын үлдэгдэл	66.3	85.4	78.1
Үүнээс: Хугацаа хэтэрсэн	2.7	1.3	4.2
Чанаргүй	11.9	11.3	11.7
Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл	127.0	167.1	153.5
Үүнээс: Хугацаа хэтэрсэн	4.6	2.8	7.4
Чанаргүй	22.5	24.3	24.6
Үндсэн үйл ажиллагааны орлого	8.3	10.6	12.2
Үндсэн үйл ажиллагааны зардал	4.1	2.6	3.6
Үндсэн үйл ажиллагааны үр дүн	4.2	8.0	8.6
Олгосон батлан даалтын тоо	69	241	40
Олгосон батлан даалтын дүн	13.5	33.7	13.7
Үүнээс: Хөдөө аж ахуй	0.8	0.6	0.3
Үйлдвэрлэл	2.8	6.5	5.4
Бөөний болон жижиглэн худалдаа	5.7	19.7	3.1
Үйлчилгээ	4.2	6.9	4.9
Батлан даалт гаргасан дундаж хугацаа /сараар/	88.5	43.8	84.8
Батлан даалт авахаар ирүүлсэн хүсэлтийн тоо	128	334	75
Үүнээс: Зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо	72	244	42

## ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2021	2022
ҮХЭХЗ–ын байгууллагын тоо	248	305
Брокерын тоо	269	319
Агентын тоо	1382	1495
Худалдаж, худалдан авч, шилжүүлсэн ҮХХ–ийн талбайн хэмжээ /м.кв/	1,302,517.44	1,971,523.8
Худалдаж, худалдан авч, шилжүүлсэн ҮХХ–ийн үнэ	852,646,134.53	1,705,302,359,633.8
Түрээслүүлж, түрээсэлж, хөлслүүлж, хөлсөлсөн ҮХХ–ийн талбайн хэмжээ /м.кв/	218,652.39	840,208.6
Түрээслүүлж, түрээсэлж, хөлслүүлж, хөлсөлсөн ҮХХ–ийн үнэ	23,564,922.66	444,145,728,252.8

**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ**

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2021	2022
Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо	40	47
Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн тоо	67	70
Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэдийн тоо	240	255
Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэгч иргэдийн тоо	129	140
Худалдан авсан үнэт металлын бохир жин /грамм/	3,965,651.87	8,490,820.76
Худалдан авсан үнэт металлын нийт үнэ	583,892,349,557.34	700,098,874,261.66
Худалдсан үнэт металлын бохир жин /грамм/	4,465,898.83	8,325,304.13
Худалдсан үнэт металлын нийт үнэ	694,444,594,444.72	670,802,317,503.07
Худалдан авсан эдлэлийн нийт үнэ	—	—
Худалдсан эдлэлийн нийт үнэ	10,879,157,956.0	14,699,352,837.17



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia